Хавсралт 1

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
## (2017 оны жилийн эцсийн байдлаар)

(“Төрийн мэдээллийн сүлжээ” http://unelgee.gov.mn –д болон ТӨБЗГ-т бүртгэсэн бүртгэл-хяналтыг үндэслэв)

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2018-01-12 Улаанбаатар хот

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалт, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч буй шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| **Нэг. Монгол Улсын хууль** | | | | | |
| 1 | 1 | **Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль.**<br>5 дугаар бүлгийн 31 дүгээр зүйлийн 5 дахь заалт: /Энэ хэсгийг 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/<br>Гүйцэтгэх ажлын зориулалттай эд хөрөнгийг худалдан авах, үйлдвэрлэх, эргэлтийн хөрөнгөд бүртгэх, захиран зарцуулах, шилжүүлэх, устгахтай холбогдох харилцааг төрийн өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тагнуулын төв байгууллагын даргатай хамтран баталсан журмаар зохицуулна. | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Гүйцэтгэх ажлын зориулалттай эд хөрөнгийг бүртгэх, захиран зарцуулах, шилжүүлэх, акталж, данснаас хасах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (цаашид ТӨБЗГ гэх)-т холбогдох байгууллагаас төрийн болон албаны нууцын журмаар ирүүлсэн санал, албан хүсэлтийг судлан шийдвэрлэж, мөн төрийн нууцын дагуу хариу өгч ажилладаг. Гүйцэтгэх ажлын зориулалттай эд хөрөнгийг худалдан авах, үйлдвэрлэх харилцаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулагдахгүй болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Хэрэгжилт тогтмолжиж, хэвшсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| | | **1 хуулийн 1 заалт** | | | |
| **Хоёр. УИХ-ын тогтоол** | | | | | |
| 2 | 2 | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай,**<br>2011-06-09, № 32 | **ТӨБЗГ – ХААХ**<br>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь захиалагчаас ирүүлсэн зураг, төсөв, | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Биелснээр | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.2. Бараа, ажил, үйлчилгээний стандартыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны хүрээнд тендер шалгаруулах болон тендерийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих гол шалгуур үзүүлэлт байх журам тогтоож мөрдүүлэх; | техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт тусгагдсан шаардлагыг үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Засгийн газар, Сангийн яамнаас батлагдсан холбогдох журмын хүрээнд Засгийн газрын худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тухайн төсөл, арга хэмжээнд тусгай зөвшөөрөл шаардах эсэх талаар төсвийн ерөнхийлөн захирагч нараас тодруулга авч, 13 яамнаас олгож буй тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэлгээний хорооноос тендерийн баримт бичиг боловсруулахад анхааран ажиллаж хэвшээд байна.<br><br>Улсын хэмжээний худалдан авах ажиллагаанд баримтлах журам тогтоож, мөрдүүлэх эрх хэмжээ ТӨБЗГ-т хуулиар олгогдоогүй болно. | тооцож хяналтаас хасах саналтай байна.<br><br>ТӨБЗГ-т хамаарахгүй. | |
| | 3 | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай,**<br><br>2011-06-09, № 32<br><br>1.3. Бараа, ажил, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, чанар стандартыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах. | **ТӨБЗГ – ХААХ**<br><br>Тайлбар: Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь худалдан авах ажиллагааны эрх бүхий улсын байцаагчаар дамжуулан мэргэжлийн байгууллага - ТӨБЗГ, Орон нутгийн нэгжийн худалдан авах ажиллагаанд хяналт тавьж ажиллах хууль, эрх зүйн зохицуулалттай. Мөн мэргэжлийн байгууллага болон орон нутгийн нэгжийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд холбогдох улсын байцаагч, захиалагч хяналт тавьж ажиллахаар хууль, журамд тусгагдсан. Бараа, ажил, үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох эрх хэмжээ ТӨБЗГ-т хуулиар олгогдоогүй.<br><br>Улсын Их Хурлын энэхүү тогтоолын 1.1 дэх заалтаар “1.1. Бүх салбарыг хамарсан бараа, ажил, үйлчилгээний стандарт, нийтээр дагаж мөрдөх норм, нормативыг шинэчлэн боловсруулан баталж, мөрдүүлэх арга хэмжээ авах;” гэж заагаад 1.3. дахь буюу энэ заалтад стандартын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, чанар стандартыг зөрчихөд хүлээлгэх хариуцлага чангатгах тухай дурдсан нь бүхэлдээ ТӨБЗГ-ын чиг үүргийн асуудал биш байх тул хяналтаас хасуулах саналтай байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Биелснээр тооцож хяналтаас хасах саналтай байна.<br><br>ТӨБЗГ-т хамаарахгүй. | |
| 3 | 4 | **Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай** | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br><br>2016 онд 810.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 779.8 сая | “Бүрэн хэрэгжсэн” | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай,**<br>2015-12-30, № 108<br>1.3. эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусад салбарын бүх шатны төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдуулан ажлын цагийг уян хатан тогтоож, үр дүнг цагаар тооцох, сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх зэргээр бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цалингийн зардлын 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлт бий болгох; | төгрөгийн гүйцэтгэл гарч 4 %-ийн хэмнэлт буюу 7.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. ТӨБЗГ-ын батлагдсан орон тоо нь 75 бөгөөд орон тооны хэтрэлтгүй байгаа болно. | – 100 %<br>Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдан мөрдөгдөж байгаа, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул хяналтаас хасах саналтай байна. | |
| | 5 | **Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай,**<br>2015-12-03, № 108<br>1.4 төсвийн зардлыг бүх шатанд хэмнэж, бууруулахтай холбогдуулан 2016 оны төсвийн жилд өр авлага үүсгэхгүй байх, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор батлагдсан урсгал зардлыг төсвийн ангилал хооронд хуульд зааснаар зохицуулалт хийж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрөх; | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах Үр дүнгийн гэрээнд байгууллагын төсвийг үр ашигтай, хэмнэлттэйгээр зарцуулж, өр, авлага үүсгэхгүй байх талаар тусгайлан заалт тусган ажиллаж байна. 2016, 2017 оны жилийн эцсийн тайлан балансаар өглөг, авлагагүй тайлагнасан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдан мөрдөгдөж байгаа, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул хяналтаас хасах саналтай байна. | |
| | 6 | **Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай,** | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ болох байр ашиглалтын зардлыг төсөвт тусган батлуулж, зарцуулсан. Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаатай байгуулсан 2016 оны 25/04 дүгээр гэрээний дагуу 61.9 сая төгрөгийн, 2017 оны 07 дугаар | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2015-12-03, № 108<br><br>1.5. нийслэл болон орон нутагт төрийн албан хаагчдын тоо, төрийн байгууллагуудын конторын барилга нэмэгдсэнээс урсгал зардал өсч байгаад дүгнэлт хийж, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын байршлыг оновчтой тогтоох, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, орон тоо болон конторын барилгын тоог бууруулж, байр ашиглалтын зардлыг хэмнэх; | гэрээний дагуу 185.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Байр ашиглалтын зардлын хэтрэлтгүй ажилласан. | батлагдан мөрдөгдөж байгаа, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул хяналтаас хасах саналтай байна. | |
| 4 | 7 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан,**<br><br>2016-11-17, № 69<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн менежментийг сайжруулах чиглэлээр:<br><br>1.4.1 улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх; | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>2016 онд төрийн өмчит 38 хуулийн этгээд ашигтай ажиллаж байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 54 компани цэвэр ашигтай ажилласан, алдагдалтай ажилласан хуулийн этгээд 18 болж 2016 оныхоос 16-аар буурсан байна. ТӨБЗГ-аас төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит 72 хуулийн этгээдийн цэвэр ашиг 2016 онд 1,105.2 сая төгрөгийн алдагдалтай байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3,442.7 сая төгрөгт хүрч, цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 3 дахин буюу 4,547.9 сая төгрөгөөр нэмэгдсэн.<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 онд улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг 2016 оны цэвэр ашгаас 15-30 хувиар тооцож, нийт 13.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 117 дугаар тогтоолоор баталсан. 2016 онд төрийн өмчийн ногдол ашгийн 4.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн бол 2017 оны жилийн эцсийн байдлаар ногдол ашгийн 12.5 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 дахин, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот түвшинтэй харьцуулахад 1.6 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна. | "Биелсэн" - 100%<br><br>Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдан мөрдөгдөж байгаа, тодорхой үр дүн гарч байгаа тул хяналтаас хасах саналтай байна. | |
| | 8 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан,**<br><br>2016-11-17, № 69 | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газарт ТӨБЗГ-аас 2016 онд "Албан даалгавар" хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Уг албан даалгаварт алдагдал, өр төлбөр, авлагыг бууруулах, үр | "Бүрэн хэрэгжсэн" – 100 %<br><br>Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.4.2 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар баталгаажсан 10.8 их наяд төгрөгийн өглөгийг бууруулах; | ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин бүрийг хангахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, түүний хэрэгжилт, үр дүнг info@pcsp.gov.mn цахим хаягаар ТӨБЗГ-т сар тутамд мэдээлж байх, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын үүрэг, хариуцлагатай холбон дүгнэх талаар тусгасан. Мөн Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дугаар албан даалгаврыг 2017 оны А-1/2963, А-1/2964, А-1/2965 дугаар албан бичгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газарт хүргүүлэн, биелэлтэд хяналт тавьж байна.<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүд 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт өглөг 2016 онд 1,241.2 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,201.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 хувь буюу 39.8 тэрбум төгрөгөөр буурсан дүнтэй байна. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг 13 компани, Төрийн банк, Хөгжлийн банкны өр төлбөрийн дүн ороогүй болно. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны өр төлбөрийн дунд Монгол Улсын Хөгжлийн банк, Төрийн банкны өр төлбөрийн нийт дүн 5.8 их наяд төгрөг орсон бөгөөд энэ нь нийт өр төлбөрийн 61.1 хувь болж байна. Үүнд дээрх банкны эх үүсвэрийг бүрдүүлэхэд үүссэн өр, үнэт цаас, бондын өр зэрэг багтсан байна. Тухайлбал, Хөгжлийн банкны өр төлбөрт Самуурай бондын өр, бусад эх үүсвэрээс авсан өр төлбөр багтсан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь үйлдвэрлэлийн техник технологи шинэчлэх чиглэлээр 1,447.4 сая төгрөгийн урт хугацаатай зээл авсан дүнтэй байна. | мөрдөгдөж байгаа тул хяналтаас хасах саналтай байна. | |
| | 9 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан,**<br><br>2016-11-17, № 69<br><br>1.4.3. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зардлыг багасгах, тэдгээрт ажиллагсдын тоог бууруулан 2012 оны түвшинд хүргэх; | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>ТӨБЗГ-аас 2016 оны 12 дугаар сард төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг авч, зарцуулагдаагүй цалин хөлс, урамшуулал, томилолт, тавилга, эд хогшил, эхлээгүй ажил, үйлчилгээний зардлыг хэмнэх, төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх асуудлыг тусгасан "Албан даалгавар"-ыг гарган хэрэгжүүлж байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 45 компанийн 32 ТУЗ, түүний дэд хороод, дотоод аудитын тайлан, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын 2016 оны тайланг 2017 оны 01-02 дугаар | "Бүрэн хэрэгжсэн" - 100 %<br><br>Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль мөрдөгдөж байгаа тул хяналтаас хасах саналтай байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | сард хэлэлцэн дүгнэж, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэв. Захирлын гэрээг цуцалсан тохиолдол гараагүй байна.<br><br>Тухайн компани ашиггүй ажилласан, их хэмжээний өр зээлтэй тохиолдолд ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүдийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзэн чөлөөлж, холбогдох хууль журмын дагуу шинээр сонгон шалгаруулж томилох чиглэл баримтлан ажиллаж байна. Холбогдох журам, үүрэг, чиглэлийг хангалтгүй биелүүлсэн төрийн өмчит 4 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 4 гишүүнийг чөлөөлж, хариуцлага тооцсон.<br><br>ТӨБЗГ-ын 2017 оны 90 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг мөрдүүлэх арга хэмжээ авч, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өр авлага бууруулах, санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, хэмнэлтийн горимд ажиллах үүрэг чиглэлийг төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад өгч, үр дүнг тооцох шийдвэр гаргасан.<br><br>Үүний үр дүнд, хөрөнгө оруулалтын зардлаас 32.7 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна.<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ажлын цар хүрээ нэмэгдсэн, ажил, үйлчилгээний нэр төрөл олширсон нөхцөл байдалтай холбоотойгоор ажиллах хүчний тоог 2012 оны түвшинд хүргэн бууруулах боломжгүй байна. | | |
| | 10 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан,**<br><br>2016-11-17, № 69<br><br>1.4.5 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, удирдлагын цалин, урамшууллыг оновчтой тогтоох. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 41 дүгээр тэмдэглэлд нэг сарын 5.0-10.0 сая төгрөгийн цалин хөлстэй этгээдийн цалингийн хэмжээг 30 хувиар бууруулах гэж заасны дагуу энэ шатлалд хамрагдах цалинтай 13 хуулийн этгээдийн удирдлагын цалинг бууруулах үүрэг даалгаврыг өгч, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, удирдлагын цалин, урамшууллыг нэмэгдүүлэхгүй байх чиглэл баримтлан ажиллаж байна. Цаашид ТӨБЗГ-аас Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, удирдлагын цалин, урамшууллыг оновчтой тогтоох талаар судалж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Тодорхой арга хэмжээ авсан, цалин, урамшууллыг нэмэгдүүлэхгүй байх чиглэл барьж байгаа. Цаашид хяналтаас хасах | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | санaлтай байна. | |
| | | **3 шийдвэрийн 9 заалт** | | | |
| **Гурав. УИХ-ын Байнгын хорооны тогтоол** | | | | | |
| 5 | 11 | **Чиглэл өгөх тухай,**<br><br>2014-12-17, № 19<br><br>4. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас хөрөнгө оруулалт хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны явцад бий болсон өмч хөрөнгийн бүртгэл хийх эрх зүйн орчинг бий болгох | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон өмч, хөрөнгийг улсын комисс хүлээн авсны дараа холбогдох байгууллага хөрөнгийг тухай бүрд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу бүртгэж байна.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2008 “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын дагуу шинээр бий болсон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн эзэмшигчийг тогтоож, хөрөнгийг бүртгэх зөвшөөрлийг олгож байна.<br><br>Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө оруулалтаар бүх нийтэд хүргэх харилцаа холбооны үйлчилгээний чиглэлээр 2015 онд нийт 1,067.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, 2016 онд нийт 2,159.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг тендерт шалгарсан компаниар гүйцэтгүүлсэн байна. Ажлын гүйцэтгэл бүрэн дууссаны дараа бий болсон хөрөнгийг улсын комисс хүлээж авсан актын дагуу 2015 онд Төрийн өмчийн хороо (хуучнаар)-нд үндсэн хөрөнгийг бүртгүүлэх санал ирүүлсний дагуу тухайн үед шийдвэрлэсэн байна.<br><br>Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэх, тоон телевизийн үйлчилгээний тасралтгүй байнгын ажиллагаа, чанар, хамрах хүрээг сайжруулах чиглэлээр нийт 1.9 тэрбум төгрөгийн 8 төслийг хэрэгжүүлсэн байна. Эдгээрийн эзэмшигчийг тогтоож, бүртгэлд хамруулах талаар одоогоор холбогдох байгууллагаас санал ирээгүй байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Хууль эрх зүйн орчинг тусгайлан бий болгох шаардлагагүй тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| | | **1 шийдвэрийн 1 заалт** | | | |
| **Дөрөв. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | 12 | **“Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулах тухай,**<br>2007-05-24, № 97<br>1. “БНМАУ-ын тусгаар тогтнолын талаархи асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай” БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны түүхэн шийдвэрийн дагуу Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулсан ард түмний санал асуулгыг явуулсан өдрийг тохиолдуулан Засгийн газар, орон нутгийн удирдлага, тэдгээрийн харъяаны бүх шатны байгууллага, албан тушаалтнууд бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, зөвлөгөөг сонсч тусгах зорилгоор жил бүрийн 10 дугаар сарын 20-нд орон даяар “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br>2017 онд 2 удаа нээлттэй өдөрлөг зохион байгуулав.<br>2017 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдөр “Тэнгэр плаза” худалдааны төвд “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага - 2017” өдөрлөг зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 88 хуулийн этгээд, 150 хувийн хэвшлийн аж ахуйн нэгж оролцов. Энэ арга хэмжээний үеэр төр, хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн 12 санамж бичиг байгуулагдан, 148.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт хийгдэж, 10200 иргэн өдөрлөгийн үйл ажиллагаанд хамрагдсан. Нийт 54364 ширхэг танилцуулга, ном товхимол, гарын авлага, зөвлөмж, бусад тараах материалыг олон нийтэд тараасан. Үйл ажиллагааны үеэр “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага - 2017” сэдэвт семинар, хэлэлцүүлэг, төрийн өмчит компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын сургалт, “Цахим худалдан авах ажиллагааны систем”–ийн нээлттэй сургалтыг тус тус зохион байгуулж, компанийн эрх бүхий нийт 284 албан тушаалтныг хамруулав.<br>2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Сүхбаатарын талбайд Үндэсний хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан. Уг арга хэмжээнд Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар болон иргэдэд шууд үйлчилгээ үзүүлдэг 13 төрийн өмчит аж ахуй нэгжийг оролцуулсан. Өдөрлөгийн үеэр давхардсан тоогоор 4200 ширхэг танилцуулга, ном товхимол, гарын авлага, зөвлөмж, бусад тараах материал тараан сурталчилгаа хийсэн. Өдөрлөгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан мэдээлсэн.<br>Эдгээр нээлттэй өдөрлөгийн хүрээнд зохион байгуулсан ярилцлага, хэлэлцүүлэг, сургалтын үеэр гарсан санал, бодлогын асуудлуудыг судлан боловсруулах бодлого, чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шийдвэр, хууль тогтоомжийн төсөлд тусгах арга хэмжээ авсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Хэрэгжилт тогтмолжсон тул цаашид хяналтаас хасах саналтай. | |
| 7 | 13 | **Монгол Улсын Төрийн тугийг хүндэтгэх тухай,** | | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2017-06-16, № 136<br>1. Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг гүнээ дээдлэн хүндэтгэж байхыг иргэдэд уриалсугай. 2. Есөн хөлт Их цагаан тугийг дууриалган үйлдсэнийг төр, олон нийтийн аливаа үйл ажиллагаанд ашиглахгүй байхыг төрийн захиргаа, нутгийн өөрөө удирдах болон холбогдох бусад байгууллагад даалгасугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br>Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг дээдлэн хүндэтгэж байх, Есөн хөлт Их цагаан тугийг дууриалган үйлдэхгүй байх, дууралйлгаж хийсэн Их цагаан тугийг төр, олон нийтийн аливаа үйл ажиллагаанд ашиглахгүй байхыг нийт албан хаагчид танилцуулав. | | |
| | | **2 шийдвэрийн 2 заалт** | | | |
| **Тав. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж** | | | | | |
| 8 | 14 | **Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай**<br>2017-07-19, № 19/5<br>Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах | **ТӨБЗГ - ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхлэх асуудлын хүрээнд энэ чиглэлээр үүссэн гомдол, маргаан байхгүй байна. Цаашид Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг анхаарч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | | **1 шийдвэрийн 1 заалт** | | | |
| **Зургаа. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 9 | 15 | **Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай**<br>2012-12-21, № 120<br>49.3 Зэсийн баяжмалыг боловсруулан цэвэр зэс үйлдвэрлэх технологийн сонголт хийж, үйлдвэрийн ТЭЗҮ-ийг олон улсын нээлттэй сонгон | **ТӨБЗГ - БТУХ**<br>ТӨБЗГ-ын чиг үүрэгт шуду хамаарах ажил биш.<br>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр шинээр батлагдан хэрэгжиж эхэлсэн, өмнөх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дууссан. | “Бүрэн хэрэгжсэн” - 100 %<br>Биелснээр тооцож хяналтаас хасах саналтай. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дуусч, дараагийн 4 жилийн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шалгаруулалтаар гүйцэтгүүлнэ. | | хөтөлбөр батлагдсан.<br>ТӨБЗГ-т хамаарахгүй. | |
| 10 | 16 | **Журам батлах тухай (хяналт-шинжилгээ, үнэлгээний)**<br>2013-09-21, № 322<br>2. Энэхүү журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол хүчингүй болж, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлагдсан.<br>Энэхүү журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний ажил зохих түвшинд хийгдэж, журамд заасан хугацаа, хуваарийн дагуу холбогдох тайланг гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд хүргүүлж хэвшсэн.<br>Иймээс “Бүрэн хэрэгжсэн” – ээр тооцож, үнэлгээ өгөв. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Биелснээр тооцож хяналтаас хасах саналтай. | Энэхүү журам шинэчлэгдэж, 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд уг тогтоолоор 2013 оны 322 дугаар тогтоолыг хүчингүй болгосон. |
| 11 | 17 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулах тухай**<br>2013-10-05, № 336<br>3. Монгол Улс ба Нордикийн хөгжлийн сан хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдлийн тооцоог гаргаж баталгаажуулах, Автотээврийн үндэсний төвтэй дамжуулан зээлдүүлэх гэрээг шинэчлэн байгуулж зээлийн эргэн төлөлтийг тус төвийн жил бүрийн зорилтот түвшинд тусган барагдуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Зам, тээврийн сайд А.Гансүх нарт даалгасугай. | **ТӨБЗГ - БТУХ**<br>Энэ тогтоолын дагуу 2001 онд 3,940,000.0 SDR–тэй (SDR-Зээлжих тусгай эрх) тэнцэх зээлийг Тээвэр хөгжүүлэх төслийн хүрээнд хуучнаар “Санхүү эдийн засгийн яам ба Авто тээврийн газар”-ын хооронд байгуулсан NDF-353 дугаартай Нордикийн хөгжлийн сангийн дамжуулан зээлдүүлэх зээлийг олгохоор болсон. Санхүү, эдийн засгийн яам “Авто тээврийн газар”-ын хооронд 2001 оны 7 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний хавсралтад өөрчлөлт оруулах 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Дугаар:122/11/55 тоот гэрээний дагуу зээлийн төлбөрийг төлж эхэлсэн.<br>2016 оны жилийн эцсийн балансаар 2,346,515.91 SDR-ийн үлдэгдэлтэй байснаас 2017 оны жилийн эцсийн балансаар 1,919,658.01 SDR-ийн үлдэгдэлийг Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтэстэй тооцоо нийлэн баталгаажуулсан. 2014 оноос хойш төгрөгөөр төлөгдөөгүй байсан үндсэн болон зээлийн хүүгийн зардал болох нийт 1,914,263,148.82 төгрөгийг 2017 онд Сангийн яамны дансанд төлсөн байна. Үүнээс үндсэн зээлийн төлбөрт 1,454,011,760,56 төгрөг, хүүгийн төлбөрт 460,251,388.26 төгрөгийг тус тус төлж, 2013-2016 он хүртэл хугацаанд хуваарийн дагуу төлөгдөөгүй 4 жилийн зээлийг нөхөн төлж дуусгав. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд уг зээлийн хүүгийн зардалд 62,000,000.00 төгрөгийг төлөхөөр тусган батлуулсан. | | |
| 12 | 18 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2013-11-30, № 391<br>1. Төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан төвлөрсөн ус хангамжийн үндсэн эх үүсвэрийн худгууд, түүний барилга байгууламжуудыг 1 дүгээр хавсралтаар “Монгол Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад шилжүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ, ТӨБХХ**<br>“Монгол-Ус” ТӨҮГ нь Засгийн газрын 2011 оны 335 дугаар тогтоолоор байгуулагдаж, ТӨХ (2016 онд татан буугдсан)-ны 2012 оны 369 дүгээр тогтоолоор тус хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталснаар үйл ажиллагаа явуулж байгаа.<br>Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 391 дүгээр тогтоолоор төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан төвлөрсөн ус хангамжийн үндсэн эх үүсвэрийн худаг 9, орон нутгийн өмчлөлд байгаа улсын төсвийн хөрөнгөөр баригдсан усны нөөцөд тохируулга хийх, хуваарилах зориулалт бүхий услалтын системийн барилга байгууламж 17, хамтарсан үйлдвэрийн өмчлөлд байгаа төвлөрсөн ус хангамжийн үндсэн эх үүсвэрийн худаг 18, цэвэрлэх байгууламж 1, нийт 45 объектыг холбогдох байгууллагатай зөвшилцөн “Монгол-Ус” ТӨҮГ-ын балансад шилжүүлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэхийг тухайн үеийн Төрийн өмчийн хороо, Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд даалгасан.<br>Хяналтаас хасах үндэслэл:<br>1. Тогтоол гаргахдаа тооцоо судалгааг дутуу, үндэслэл муутай хийсэн (Жишээ нь: Өвөрхангай аймгийн Хархорин суман дахь Хархорины услалтын систем хувьчлагдсан байтал 2 дугаар хавсралтын жагсаалтад орсон),<br>2. Эрдэнэтийн Уулын баяжуулах үйлдвэрийн усны эх үүсвэрийн 14 худаг, Орхон аймгийн Баян-Өндөр сумын цэвэрлэх байгууламж, Дулааны цахилгаан станц 2, 3, 4 ТӨХК-иудын эзэмшлийн газар байрлах ус хангамжийн үндсэн эх үүсвэрийн худгууд, түүний барилга, байгууламжууд нь онцгой объект тул балансаас балансад шилжүүлэх боломжгүй,<br>3. Хавсралтад дурдсан объектыг балансаас балансад авсны дараа ямар хөрөнгийн эх үүсвэрээр, ямар зардал гаргаж цаашид ажиллах нь тодорхойгүй,<br>4. Тогтоол гаргахдаа яам, агентлаг, холбогдох аж ахуйн нэгжийн саналыг аваагүйгээс хэрэгжүүлэхэд хүндрэл гарсан байна.<br>“Монгол-Ус” ТӨҮГ нь Засгийн газрын 391 дүгээр тогтоолыг | “Хэрэгжээгүй” – 0,<br>Хэрэгжих боломжгүйн улмаас сүүлийн 3 жил хэрэгжилт тасарсан тул хяналтаас хасах саналтай. | Орон нутгийн өмчөөс төрийн өмчид эд хөрөнгө шилжүүлэхэд ТБОНӨТХуулийн 77.2.3-т заасны дагуу аймаг, нийслэлийн ИТХ-аас хөрөнгө шилжүүлэх шийдвэр гаргах бөгөөд ийм шийдвэр гараагүй тохиолдолд Төрийн өмчийн хороо дангаараа шийдвэрлэх боломжгүй.<br>Компанийн тухай хуулийн дагуу төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх бөгөөд ийм шийдвэр гараагүй тохиолдолд энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх боломжгүй. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэх, усны барилга байгууламжийг балансаас балансад шилжүүлэн авч ашиглах талаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон хуулийн этгээдэд албан бичиг хүргүүлж байсан боловч хариу ирээгүй, эсвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөөгүй байна.<br><br>Иймд энэхүү тогтоол бүхэлдээ хэрэгжих боломжгүй байгаа. | | |
| | 19 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2013-11-30, № 391<br><br>3. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтад заасан хамтарсан үйлдвэрийн өмчлөлд байгаа төвлөрсөн ус хангамжийн үндсэн эх үүсвэрийн худгууд, цэвэрлэх байгууламжуудыг хамтарсан үйлдвэрийн зөвлөлтэй зөвшилцөж "Монгол Ус" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад шилжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ, ТӨБХХ**<br><br>Дээрх заалтын адил хэрэгжээгүй бөгөөд тайлбар ижил. | “Хэрэгжээгүй” – 0,<br><br>Хэрэгжих боломжгүйн улмаас сүүлийн 3 жил хэрэгжилт тасарсан тул хяналтаас хасах саналтай. | |
| 13 | 20 | **Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай,**<br><br>2014-01-28, № 18<br><br>2. Тендерт оролцогчдод давуу эрх олгосон талаарх мэдээг худалдан авах ажиллагааны улирлын тайланд дэлгэрэнгүй тусган Сангийн яаманд тухай бүр хүргүүлж байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ХААХ**<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 онд баталсан “Давуу эрх тооцох аргачлал” зэргийг мөрдлөг болгон ажиллах хүрээнд давуу эрх тооцох тухай заалтыг тендерийн баримт бичигт тусган холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Давуу эрх тооцох аргачлалыг тодорхой болгох шаардлагатай байгаа тул 2007 онд Сангийн сайдын баталсан давуу эрх тооцох аргачлалын төсөлд тусгах санал боловсруулж, 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/14 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br><br>Тендерт оролцогчоос тендер ирүүлэхдээ дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт тавьж, хуульд заасан холбогдох баримт, материалыг ирүүлсэн тохиолдолд давуу эрхийг батлагдсан аргачлалын дагуу тооцон ажиллаж хэвшсэн.<br><br>ТӨБЗГ 2017 онд нийт 68 төсөл, арга хэмжээний 109 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх тооцох тухай, дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх тухай шаардлагыг тус тус тусгасан. Тайлант хугацаанд ТӨБЗГ-аас зарласан тендерт оролцогч 37 аж ахуйн нэгж дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт ирүүлснийг тооцон ажилласан байна.<br><br>2016 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайлан, 2017 оны улирлын тайланг 2017 оны 1/66, А-1/655, А-1/1697, А-1/2651 дүгээр албан бичгээр тус тус тухай бүр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага – Сангийн яаманд хүргүүлсэн. Тайланд давуу эрх тооцсон тухай тусган мэдээлсэн. | | |
| 14 | 21 | **Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2015-01-26, № 27<br><br>3. Эрдэм шинжилгээний байгууллагуудын үндсэн хөрөнгө, дэд бүтцийг хэвээр хадгалан, чиг үүргийнх нь дагуу ашиглуулах, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт үйлдвэрлэл, бизнесийн корпораци (хуучин нэрээр)-ийн байрлаж байсан байранд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнг нүүлгэн байршуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Эрдэм шинжилгээний байгууллагуудын үндсэн хөрөнгө, дэд бүтцийг хэвээр хадгалан, чиг үүргийнх нь дагуу ашиглуулах, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт үйлдвэрлэл, бизнесийн корпораци (хуучин нэрээр)-ийн байрлаж байсан байранд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнг нүүлгэн байршуулах чиг үүрэгтэй ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын шийдвэрээр 2015 онд байгуулсан боловч тодорхой ажил хийгдээгүй болно.<br><br>Энэ заалтаар өгсөн асуудалтай холбоотой Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 194 дүгээр тогтоол сүүлийн хугацаанд гарсан бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн байна. Тиймээс уг тогтоолыг “Бүрэн хэрэгжсэн” - 100 % гэж тооцон хяналтаас хасах нь зүйтэй. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>2016 оны 194 дүгээр тогтоолоор уг асуудал өөрчлөгдөн шийдвэрлэгдсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | Энэхүү заалтад Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт орж, улмаар 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 68 дугаар тогтоолоор хүчингүй болсон.<br><br>Засгийн газрын 2016 оны 68 дугаар тогтоолыг 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 35 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. |
| 15 | 22 | **2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай**<br><br>2015-08-17, № 330 | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Энэхүү тогтоолоор батлагдсан жагсаалтад заасан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулах ажлыг хэрэгжүүлэх хүрээнд 2015-2017 онд “Кино урлагийн дээд сургууль” ХХК, “Хөтөлийн цемент шохой” | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хугацаа дууссан, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2. Жагсаалтад заасан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулах ажлыг холбогдох яамтай хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, явц, үр дүнг сар тутам Засгийн газарт танилцуулж байхыг Сангийн сайд, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж), “Эрдэнэс Монгол” ХХК (Б.Бямбасайхан)-д тус тус даалгасугай. | ТӨХК, “Оргил рашаан сувилал” ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг бүрэн худалдаж, нийт 16.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээр төрийн өмчийн оролцоогүй болж, хувьд бүрэн шилжсэн. Мөн 2015-2016 онд “Монгол шуудан” ТӨХК, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-иас нэмэлт хувьцаа гарган худалдаж, 7.4 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн бөгөөд эдгээр компани нь төрийн өмчийн оролцоотой компани болж, нийт хувьцааны тодорхой хувь нь хувьд шилжсэн. 2017 оны жилийн эцсийн байдлаар "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн биелэлт 20.0 хувь буюу хэрэгжилтийн явц удаашралтай байсан. Энэ нь Засгийн газрын бүтэц 4 жил тутамд өөрчлөгдөж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт орсон, салбар хоорондын бодлогын уялдаа холбоо хангалтгүй зэрэг дотоод, гадаад хүчин зүйлээс шалтгаалж байна.<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 300 дугаар тогтоолоор “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 40 хувийг эзэмшигч “Кореа телеком” корпорацийн эзэмшиж байсан хувьцааг солонгосын талын санал болгосны дагуу худалдан авахаар шийдвэрлэв. Засгийн газрын энэхүү тогтоолын дагуу Сангийн яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл оролцсон ажлын хэсэг ажиллаж, 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулав. Үүний үр дүнд, Монгол Улсын үндэсний хэмжээний томоохон компанийн үйл ажиллагааг сайжруулж, үнэлэмжийг өсгөн, нэгж хувьцааны үнийг Хөрөнгийн биржээр дахин үнэ хүргэж арилжих нөхцөл бүрдсэн.<br><br>“2017 онд хувьчлах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ыг боловсруулан Засгийн газрын тогтоолын төслийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч тодорхой шийдвэр гараагүй байна. | Засгийн газрын бодлого, чиглэлтэй уялдуулан уг үндсэн чиглэлийг шинэчлэн батлуулах арга хэмжээг авч байгаа тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 16 | 23 | **Жагсаалт батлах тухай,**<br><br>2015-08-17, № 336<br><br>2. Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж, жил бүрийн худалдан авахаар батлуулсан | **ТӨБЗГ – ХААХ**<br><br>Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх шаардлагыг 2017 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичиг бүрт тусгасан. Дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан мэдээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 1 дүгээр сард багтаан үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагчдад үүрэг болгосугай. | Чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг хэрхэн тодорхойлох талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Стандарт, хэмжил зүйн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хамтарсан уулзалтыг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. | | |
| 17 | 24 | **Дунд хугацааны стратеги батлах тухай (Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги)**<br><br>2015-10-05, № 396<br><br>3. Дунд хугацааны стратегийн зорилт, арга хэмжээг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – БТУХ, ХААХ**<br>“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн холбогдох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж байна. Үүнд:<br><br>2017 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдөр “Тэнгэр плаза” худалдааны төвд “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага - 2017” өдөрлөг зохион байгуулсан. Тус өдөрлөгийн арга хэмжээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 88 хуулийн этгээд, 150 хувийн хэвшлийн аж ахуйн нэгж оролцов. Өдөрлөгт оролцогч байгууллага, ААН нь үйлчилгээгээ нэг цэгээс иргэдэд хүргэх, бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилснаар импортыг орлох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэрүүдийг дэмжих, хамтарч ажиллах нөхцөлийг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилтыг хангах арга хэмжээ болов. Энэ арга хэмжээний үеэр төр, хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн 12 санамж бичиг байгуулагдан, 148.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт хийгдэж, 10200 иргэн өдөрлөгийн үйл ажиллагаанд хамрагдсан.<br><br>2017 онд нийт 68 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулахаас тендер зарласан 109 багц ажлын тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх тооцох тухай, дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх шаардлагыг тус тус тусгасан. Тайлант хугацаанд ТӨБЗГ-аас зарласан тендерт оролцогч 37 аж ахуйн нэгж дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт ирүүлснийг тооцон ажилласан байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 18 | 25 | **Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн талаар авах зарим арга** | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **хэмжээний тухай,** 2015-10-19, № 408 3. Энэ тогтоолын 1, 2 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд даалгасугай. | балансаас балансад шилжүүлэх, Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн балансад бүртгэлтэй 3 өрөө орон сууцыг хувьчлах асуудлыг тухайн үеийн Төрийн өмчийн хорооны 2015.12.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Мөн “Багануур” АЗЗА ТӨХК-ийн зорчигчдын амралтын цогцолборыг Цагдаагийн ерөнхий газарт, Ашигт малтмалын газрын эзэмшиж байсан Эрчим хүчний яамны өргөтгөл, судалгаа, шинжилгээний лабораторийг “Эрчим хүчнийн хөгжлийн төв” ТӨҮГ-т, Гаалийн ерөнхий газрын “Жигүүр” амралтын газрыг Хил хамгаалах ерөнхий газарт, Богдын зуны ордон, торгон цэргийн байрыг Богд хааны ордон музейд, “Монсам” ХХК-ийн үйлдвэрийн барилга, орон сууцыг Сангийн яаманд тус тус шилжүүлэх ажлыг бүрэн хийж дуусгасан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй конторын барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэж, худалдан доод үнэ, дэнчингийн хэмжээг тогтоосон. Дуудлага худалдааг нээлттэй зарлан зохион байгуулж, ялагч иргэн А.Золзаяад 47.0 сая төгрөгөөр худалдаж, өмчлөгчийн эрхийг шилжүүлэх шийдвэр гарган, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэв. Засгийн газрын 2017 оны 131 дүгээр тогтоолоор Худалдаа, үйлдвэрлэлийн сургуулийн салбар сургуулийг Баянхонгор аймагт байгуулж, Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн байр, эд хөрөнгийг Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн балансад шилжүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан учир барилгыг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлыг зогсоосон. | Цаашид хяналтаас хасах саналтай байна, тогтоолд заасан арга хэмжээ бүрэн шийдвэрлэгдсэн. | |
| 19 | 26 | **Бүтэц, зохион байгуулалтын зардлын талаар авах зарим арга хэмжээний тухай,** 2016-11-16, № 142 3. Энэ тогтоолын 1, 2 дугаар зүйлд заасан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хуульд заасны дагуу тайлагнахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт | **ТӨБЗГ – ЗХЗХ** Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 37 дугаар захирамжаар батлагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн чиг үүргийн дагуу зарим албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг хэвээр хадгалагдах боломжгүй болж, татан буугдсан ХААГ-ын нийт 19 албан хаагчид 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг хуульд заасны дагуу олгох асуудлыг шийдвэрлэх шаардлага үүссэн. Нэр бүхий 19 албан | “Бүрэн биелсэн” – 100 % Цаашид хэрэгжих боломжгүй болсон тул хяналтаас хасах саналтай байна. | Хөрөнгө дутагдсанаас шалтгаалж хэрэгжихгүй байна. Хөрөнгийн асуудлыг ТӨБЗГ-аас шууд хамаарч |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | даалгасугай.<br><br>(1. Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэрээр төсвийн зарим байгууллагад хийсэн бүтцийн өөрчлөлттэй холбогдож гарсан төсөвт урьдчилан тусгах боломжгүй зардалтай холбоотой дараах асуудлыг 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрөөр тасалбар болгон эцэслэн шийдвэрлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:<br><br>1.1. цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын өр төлбөрийг барагдуулах;<br><br>1.2. байгууллагыг татан буулгаж, чиг үүргийг нь орон тооны хамт цомхотгосны улмаас ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал;<br><br>1.3. бүтцийн өөрчлөлттэй холбоотой шийдвэрийг зохион байгуулах үүрэг бүхий комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааны төсөвт тусгагдаагүй нэмэлт зардал, татан буугдсан буюу өөрчлөн байгуулагдсан байгууллагын архив, эд хогшлыг нүүлгэн шилжүүлэхэд гарсан бусад зардал.<br><br>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан зардалд шаардагдах хөрөнгө тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсөвт тусгагдаагүй тохиолдолд нэмж шаардагдах хөрөнгийг 2016 оны улсын төсвийн бүтцийн өөрчлөлтийн зардлаас санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвшөөрсүгэй.) | хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох зардлын тооцоог хийсэн бөгөөд Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын газрын даргад хандан ТӨБЗГ-ын 2016-09-07-ны өдрийн 1/82, 2017-02-02-ны өдрийн А-1/189, 2017-05-25-ны өдрийн А-1/1202 дугаар албан бичгээр нийт 3 удаа хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.<br><br>19 албан хаагчид 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгох асуудлыг 2018 оны төсвийн төсөлд тусгах санал өгсөн боловч ТӨБЗГ-ын 2018 оны төсвийн хязгаарыг 2017 оны төсвийн хязгаараар тогтоосон тул 2018 онд мөн олгох боломжгүй байна.<br><br>ТӨБЗГ-аас шаардлагатай арга хэмжээг авсан боловч 2017 оны жилийн эцэс гэхэд шийдвэрлэгдээгүй, цаашид хэрэгжих боломжгүй болсон гэж үзэн хэрэгжилтийг “Бүрэн биелсэн”-ээр тооцож, хяналтаас хасуулах саналтай байна.<br><br>Энэ заалтын хэрэгжилт тус байгууллагаас шууд хамаарахгүй байна. | | шийдвэрлэх боломжгүй.<br><br>2017 оны хагас жилийн тайланг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд хяналтаас хасуулах шаардлагатай гэж тэмдэглэлд тусгагдсан. |
| 20 | 27 | **Жагсаалт батлах тухай (Худалдан авах ажиллагаа)**<br><br>**2016-11-23, № 152**<br><br>2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт, холбогдох зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг хуульд заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус | **ТӨБЗГ – ХААХ**<br><br>Энэ тогтоолоор батлагдсан жагсаалтад дурдагдсан 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 60.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 30 төсөл, арга хэмжээний 55 багц ажлын худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулав.<br><br>55 багц ажлын явцын дүн:<br>1. Гэрээ байгуулсан - 35 багц ажил;<br>2. Гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн - 2 багц ажил;<br>3. Захиалагчид буцаасан – 4 багц ажил;<br>4. Тендерийн нээлт хийсэн, үнэлгээ хийж буй – 12 багц ажил;<br>5. Захиалагчаас техникийн тодорхойлолт, ажлын даалгавар ирүүлээгүй - 1 багц ажил;<br>6. Захиалагчид зөвлөмж хүргүүлсэн – 1 багц ажил.<br><br>2017 онд зохион байгуулах нийт ажлын 76.4 хувь нь бүрэн | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | ТӨБЗГ-аас шууд хамааралгүй. Захилагч байгууллагаас ТӨБЗГ-т ирүүлэх материал удаашрч ирсэн, бусад байгууллагаас 5, 6 –р сард эрх шилжиж ирсэн ажлуудтай |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тус даалгасугай. | хэрэгжсэн, 21.8 хувь нь хэрэгжиж байгаа, захиалагчаас зураг төсөл, холбогдох материал ирүүлээгүйгээс 1.8 хувь нь хэрэгжих боломжгүй байна.<br>Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан төсвийн урсгал зардлаар худалдан авдаг 4 төрлийн барааны худалдан авах ажиллагааг Ерөнхий гэрээ байгуулах журмаар зохион байгуулах ажил хүлээгдэж байна. Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээ байгуулан худалдан авахаар нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан. Тендерийн нээлтийг 2018 оны 01 дүгээр сард хийнэ. | | холбоотой. |
| 21 | 28 | **Улсын төсөвт үйлдвэрийн газрыг өөрчлөн зохион байгуулах тухай,**<br>2016-12-07, № 177<br>3. "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" улсын үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоон мөрдүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) нарт даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>"Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" улсын үйлдвэрийн газрын захирлыг томилоход санал авах тухай Сангийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 4-2/1568 дугаар албан бичгийг судалж, дэмжсэн хариу хүргүүлэв. Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоох чиг үүрэг Сангийн яаманд хамаарна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 %<br>ТӨБЗГ-т хамраарахгүй. Сангийн яамны харьяа байгууллага тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна. | |
| 22 | 29 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-12-21, № 193<br>1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>ТӨБЗГ-аас Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн Өмчийн харилцааны газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрыг мэргэжил, арга зүйгээр ханган төрийн өмчит хуулийн этгээдэд албан даалгавар, зөвлөмж хүргүүлэн тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/110 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, Монгол Улсад болон гадаад улс оронд байгаа төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал, заавар, журам, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх, үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг СЯ, БХБЯ, ГХЯ, ТӨБЗГ, НӨХГ, | "Хэрэгжих шатанд" – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ГХГЗЗГ-ын төлөөллийг оролцуулан байгуулав.<br>Төрийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлын төсвийг боловсруулан 2018 оны төсөвт 403.2 сая төгрөгийг тусгуулж, хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, үнэлгээний ажлын бэлтгэлийг хангуулах, судалгаа хийх асуудлаар зөвлөмж хүргүүлэв.<br>Мөн төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогоор илэрсэн зөрчлийг арилгах, бүртгэлгүй хөрөнгийг бүртгэлд тусгах, дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн нэгжтэй хамтран зохион байгууллаа. Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгийг тухай бүр орон нутгийн өмчид бүртгэж байх асуудлыг нийслэлийн Өмчийн харилцааны газар болон аймгийн Орон нутгийн өмчийн газар хариуцан гүйцэтгэж байна. | | |
| | 30 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-12-21, № 193<br>2. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын эзэмшилд байгаа Монгол Улсын төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг тухайн орны үнэлгээний жишигт нийцүүлэн үнэлүүлж санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулахыг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/110 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, Монгол Улсад болон гадаад улс оронд байгаа төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал, заавар, журам, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх, үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг СЯ, БХБЯ, ГХЯ, ТӨБЗГ, ГХГЗЗГ, НӨХГ-ын төлөөллийг оролцуулан байгуулав. Ажлын хэсэг дээр дурдсан тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу шаардлагатай ажлуудыг үе шаттайгаар төлөвлөгөөний дагуу гүйцэтгэн ажиллаж байна. ГХЯ-аар дамжуулан гадаад улс дахь Монгол Улсын төрийн өмчийн үнэлгээний өнөөгийн байдлын талаарх судалгааг бэлтгэж, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ мэдээллийг бүрдүүлэж байна. Мөн Монгол Улсад байгаа гадаадын төлөөлөгчийн газарт түрээсээр ашиглуулж буй барилга байгууламж, тусгай хэрэгцээний газрын судалгааг гаргаж, үнэлгээ хийх бэлтгэлийг хангаж ажилласан. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |
| | 31 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Концессын гэрээгээр гүйцэтгэсэн ажлын үр дүнд бий болсон хөрөнгийн талаарх мэдээллийг авахаар Төрийн өмчийн бодлого, | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” - ХБ | Үндэсний хөгжлийн газарт даалгасан, ТӨБЗГ-аас |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2016-12-21, № 193<br>3. Концессын гэрээний дагуу барьж байгуулсан барилга, зам, гүүрийн байгууламж, тоног төхөөрөмж болон бусад концессын зүйлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, төрийн өмчийн бүртгэлд тусгах асуудлыг тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлж байхыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасугай. | зохицуулалтын газрын 2017 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А-1/337 дугаар албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хандан хүсэлт хүргүүлсэн. 2017 онд концессын гэрээний дүнд бий болсон хөрөнгө, концессын зүйлийг төрийн өмчийн бүртгэлд бүртгүүлэх асуудлаар ТӨБЗГ-т хандан шийдвэрлүүлсэн тохиолдол гараагүй байна.<br>Үндэсний хөгжлийн газраас концессын гэрээгээр гүйцэтгүүлж байгаа зам, барилгын ажлын гүйцэтгэл 95 хувьтай бөгөөд дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэгдэж байгаа гэсэн мэдээлэл ирүүлсэн. 2018 онд ашиглалтад орж, улсын комисс хүлээн авч акт үйлдсэний дараа төрийн өмчид бүртгэх ажил хийгдэнэ. | | шууд хамаарахгүй. |
| | 32 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-12-21, № 193<br>5. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх болон тухайн хөрөнгийг төрийн байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг судлан, тодорхой санал боловсруулж, 2017 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн 2016 оны тооллогоор нийт 42700 барилга байгууламж тоологдсноос нийт 30000 гаруй барилгыг улсын бүртгэлд бүртгүүлэх урьдчилсан тооцоо гарсан. Эдгээр барилга байгууламжийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд гэрчилгээний үнэд тус бүр 10.0-40.0 мянган төгрөг, тэмдэгтийн хураамж төлөх зэргээр төсвийн зардал ихээхэн нэмэгдэхээр байна. Төрийн өмчийн барилга, байгууламжийг эд хөрөнгийн эрхийн бүртгэлд хамруулахын тулд хуулийн дагуу төлөх шимтгэл хураамжийн зардлыг нарийвчлан тооцож, төсөвт тусгах шаардлага гарахаас гадна холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарч байна. Иймээс, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, ТӨБЗГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Б-03/А-28 дугаар бүхий хамтарсан тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн өмчлөх эрх болон төрийн байгууллагад хөрөнгө эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлаар санал боловсруулан, шийдвэрлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан ажиллуулж байна. Ажлын хэсгээс гарсан саналыг судалж, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд холбогдох зохицуулалтыг тусгах талаар ТӨБЗГ-ын 2017 оны А-1/1548 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд санал хүргүүлэв. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Ажлын хэсэг I улиралд байгуулагдсан.<br>ТӨБЗГ-аас холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэрэгжүүлсэн.<br>ТӨБЗГ-аас шууд хамаарахгүй. |
| | 33 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ТӨБХХэлтэс**<br>Аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн газрын холбогдох ажилтныг оролцуулан 2017 оны 03 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд зохион байгуулсан семинарын үеэр 09 дүгээр сард | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2016-12-21, № 193<br><br>7. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 70 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шилжүүлэх, худалдах, устгах, өмчлөлийн талаар маргаантай байгаа хөрөнгийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээг холбогдох яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран авч хэрэгжүүлэн, нэгдсэн дүнг 2017 онд багтаан Засгийн газарт оруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | багтаан энэ асуудлаар биелэлт, тайлан ирүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгч, зөрчил арилгуулах арга хэмжээ авч ажиллав.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор илэрсэн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах, дуусаагүй барилга байгууламжийг судлан зохих шийдвэр гаргуулах асуудлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн Орон нутгийн өмчийн газраас тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд дутагдсан хөрөнгийг төлүүлэх, бүртгэлгүй хөрөнгийг бүртгэлд тусгах, маргаантай хөрөнгийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан тухай тайланг ирүүлсэн.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн бүх хуулийн этгээдийн дуусаагүй барилга байгууламжийн улсын нэгтгэл гарган боловсруулалт хийж, нэгдсэн дүнг ЗГХЭГ-т танилцуулсан.<br><br>ЗГХЭГ-аас УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Сангийн яаманд тайланг хүргүүлсэн.<br><br>Сангийн яамны хөрөнгө оруулалтын газраас дуусаагүй барилгатай холбоотой мэдээллийг судалж, ТӨБЗГ-тай хамтран ажиллаж байна. | | |
| 23 | 34 | **Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах, үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай,**<br><br>2016-12-21, № 194<br><br>2. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг баталж мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т, үйл ажиллагаанд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэн хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХэлтэс**<br><br>ТӨБЗГ-ын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 52 дугаар тогтоолоор “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг томилж, контрактын гэрээ байгуулан ажиллаж байна. ТӨБЗГ-ын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг баталсан бөгөөд зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг тус ТӨҮГ-ын захирал Ц.Содномдамбад даалгасан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Тогтоолын заалтаар өгсөн үүрэг бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| | 35 | **Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах, үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх** | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 06 | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **тухай,**<br>2016-12-21, № 194<br>4. Энэ тогтоолын 3 дугаар зүйлд заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | дугаар сарын 13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/08 дугаар тушаал гарсан. Ажлын хэсгээс тогтоолын хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах үүргийг ШУТИС-д өгсний дагуу тус сургуулийн захирлын 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/197 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, үл хөдлөх болон холбогдох бусад эд хөрөнгийг хүлээлцэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн. | Тогтоолын заалтаар өгсөн үүрэг бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 24 | 36 | **УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай**<br>2016-12-28, № 219<br>2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу санхүүгийн тайландаа тусгахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Хөгжлийн банкнаас 2012-2017 онд санхүүжүүлсэн эргэн төлөгдөх нөхцөлтэй 1,484.5 тэрбум төгрөгийн зээлийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлан тэнцэлд тусгах талаар хөндлөнгийн аудит хийж буй аудитын байгууллагын зөвлөмжид тусгуулах замаар төрийн өмчит 9 компанид чиглэл өгч, зээлийн төлөлтөд хяналт тавин ажиллаж байна.<br>Үүний үр дүнд, 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хөгжлийн банкинд төрийн өмчит компанийн төлөх зээлийн төлбөр 764.7 тэрбум төгрөг болж, 619.8 тэрбум төгрөгөөр буурсан дүнтэй байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 25 | 37 | **Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулах тухай,**<br>2017-01-04, № 2<br>2. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>ТӨБЗГ-ын 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 93 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг томилсон. ТӨБЗГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 253 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг баталсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Тогтоолын заалтаар өгсөн үүрэг бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 26 | 38 | **Аялал жуулчлалыг хөгжүүлэх** | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.** | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **талаар авах зарим арга хэмжээний тухай,**<br><br>2017-01-04, № 6<br><br>4. Олон улсын гэрээ, конвенцид заасан болон олон улсын байгууллагаас тогтмол зохион байгуулдаг хурал, зөвлөгөөн, арга хэмжээнээс бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулах олон улсын хурал, зөвлөгөөнийг жил бүрийн 9 дүгээр сараас дараа оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд зохион байгуулж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай. | 2017 онд олон улсын хурал, зөвлөгөөн төлөвлөгдөөгүй. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 27 | 39 | **Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулах тухай,**<br><br>2017-01-18, № 19<br><br>2. “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулагдаж байгаатай холбогдуулан тус нэгдлийн дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг зохих журмын дагуу батлан, үйл ажиллагааг нь хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>ТӨБЗГ-ын шууд хариуцах чиг үүрэгт уг нэгдэл хамаарахгүй, БСШУСЯ-ны шууд харьяалах байгууллага болно.<br><br>Үйл ажиллагааг нь хэвийн явуулах боломж нөхцлөөр хангасан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>ТӨБЗГ-ын зүгээс өөрийн үүрэгт ажлаа хийсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 28 | 40 | **УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай**<br><br>2017-02-01, № 42<br><br>1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн зээлийн | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А-1/977 дугаар албан бичгээр Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн саналын дагуу тус яамнаас байгуулагдсан Ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөллийг ажиллуулж байна. “Аж үйлдвэрийн | “Хэрэгжих шатанд” – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | багцыг Хөгжлийн банкнаас Засгийн газарт шилжүүлэхтэй холбогдуулан төсөл санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн банктай байгуулсан холбогдох зээлийн гэрээг дүгнэж эрх үүргийг шилжүүлэн авах, дуусгавар болгох, баримт бичгийг хэлэлцэх үүрэг бүхий Ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | цогцолбор" ТӨХК-ийн өр төлбөрийн асуудлыг Ажлын хэсэг хэлэлцээд тус компанийн ТУЗ-өөр шийдвэр гаргуулах чиглэлийг баримтлан ажилласан.<br>"Аж үйлдвэрийн цогцолбор" ТӨХК-ийн Хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээг дүгнэх, дүгнэсэн актад гарын үсэг зурах эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд олгосон бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс зээлийн гэрээг дүгнэж, гарын үсэг зурах бэлтгэл хангаж, холбогдох баримт материалыг судлан бүрдүүлж байна. | | |
| | 41 | **УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай**<br>2017-02-01, № 42<br>2. Ажлын хэсгийн тайлан, үр дүнг 2017 оны 2 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг төслийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>"Аж үйлдвэрийн цогцолбор" ТӨХК-ийн зээлийн хөрөнгөтэй холбоотой асуудлыг Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас байгуулагдсан Ажлын хэсэг хариуцаж байна. Холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэд байгуулагдсан уг Ажлын хэсэг Засгийн газарт ажлаа танилцуулж байгаа бөгөөд ТӨБЗГ-ын зүгээс ажлын хэсгийн мэдээлэлтэй танилцсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд байгуулагдсан Ажлын хэсэгт уг компанийн хөрөнгийг хүлээлцэх, гэрээ дүгнэсэн актад гарын үсэг зурахтай холбоотойгоор ТӨБЗГ-ын төлөөлөл оролцож, хамтран ажиллаж байгаа.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хамааралгүйгээр гэрээ дүгнэх ажил хойшлогдсон болно. | "Хэрэгжих шатанд" – 70 % | |
| 29 | 42 | **Цогцолборыг шилжүүлэх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх тухай,**<br>2017-02-08, № 48<br>2. Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM)-ыг Батлан хамгаалах яамны балансад шилжүүлэн тусгах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ, ТӨБХХ**<br>Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM)-ыг Батлан хамгаалах яамны балансад шилжүүлэн тусгах арга хэмжээ авах үүрэг бүхий ажлын хэсэг Батлан хамгаалахын сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ТӨБЗГ-ын төлөөлөл томилогдон ажиллаж байна. Ажлын хэсэг 4 удаа хуралдаж холбогдох судалгаа, тооцоог хийсэн. Цогцолбор нь Хөгжлийн банкны зээлийн барьцаанд байгаа, гааль, НӨАТ төлөөгүйн улмаас гаалийн баталгаат агуулахад битүүмжлэгдсэн, удирдлагуудыг шалгаж байгаа шалтгаанаар Авлигатай тэмцэх газар давхар битүүмжилсэн байсан. 2017 оны 07 дугаар сард 8 ширхэг контейнерийг гаалийн агуулахаас авч, Батлан хамгаалах яамны Барилгын цэргийн ... дугаар ангид зөөвөрлөн байршуулж, | "Хэрэгжих шатанд" – 70 %<br>(ТӨБЗГ-ын оролцооны ажил хийгдсэн, тус байгууллагаас үл шалтгаалж байгаа) | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нээсэн бөгөөд дотор нь байгаа бүх хөрөнгийн жагсаалтыг гаргаж, фото болон видео зураг авалт хийн баталгаажуулж хүлээлгэн өгсөн.<br>Хөгжлийн банкны зээл, гааль, НӨАТ-ын өр, төлбөрийн асуудал шийдэгдээгүй тул “ТОСК” ТӨҮГ-ын балансаас хасч шилжүүлэх боломжгүй байна. Мөн туршиж тохируулах бэлдэц байхгүй тул ажиллуулж үзээгүй. “ТОСК” ТӨҮГ-тай хамтран гааль, НӨАТ-ыг суутган тооцох, өр төлбөрийг Сангийн яаманд шилжүүлэх талаар ажлын хэсгээс санал боловсруулж танилцуулсан, өр төлбөрийн асуудал шийдвэрлэгдсэний дараа цогцолборыг Батлан хамгаалах яамны балансад шилжүүлнэ. | | |
| 30 | 43 | **Журам шинэчлэн батлах тухай (Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам)**<br>2017-03-15, № 89<br>2. Энэхүү журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Байгууллагын хэмжээнд мөрдөх хяналт-шинжилгээ, үнэлгээний журам, аргачлал, мэдээ, тайлангийн графикт хуваарийн төслийг боловсруулж, 2018 онд Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөсөн. Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын тогтоолоор батлагдсан энэхүү журамд заасан арга зүй, аргачлалын дагуу хийж, журамд заасан хугацаа, хуваарийг баримтлан ажиллаж байгаа. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |
| 31 | 44 | **Тогтоол хүчингүй болгох тухай,**<br>2017-03-20, № 96<br>5. Энэ тогтоолын 3 дугаар зүйлд заасны дагуу хөндлөнгийн аудит хийлгэхэд шаардагдах зардлыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгах замаар шийдвэрлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Нямосор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ТӨБЗГ-ын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 306 дугаар тогтоолоор баталсан тул уг зардал тусгагдаагүй болно. 2018 оны зорилтот түвшингийн тодотголд тусгахаар болсон. | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 32 | 45 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2017-03-29, № 102<br>1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, “Роял Грийн Вилла” хотхоны 62/8 дугаар байрны Б1/103 тоотод байрлах 160 м.кв талбай бүхий орон сууц, мөн байрны зоорийн давхрын 2 тоот автомашины зогсоол, Г62/10 дугаар байрны 59 тоот автомашины зогсоолыг тус тус нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууц, зогсоолыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай асуудлыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, 2017 оны 252 дугаар тогтоолоор худалдах доод үнэ, дэнчингийн хэмжээг тогтоож, нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулахаар шийдвэрлэв. Уг шийдвэрийн дагуу нээлттэй дуудлагын худалдаа явуулах тухай зар мэдээг Өнөөдөр сонин болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан зарлан мэдээлсэн. Нээлттэй дуудлага худалдааг 3 удаа зарлан зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу орон сууц, зогсоолын дуудлагын худалдааг дахин явуулах, худалдах доод үнийг бууруулах эсэх асуудлыг Газрын хуралдаанаар хэлэлцүүлж, дуудлагын худалдааг зохион байгуулахаар хүлээгдэж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Нээлттэй дуудлага худалдааг 3 удаа зарласан боловч нэг ч оролцогч ирээгүй тул удааширч байна. |
| | 46 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2017-03-29, № 102<br>2. Дуудлагын худалдааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Дуудлагын худалдаагаар хөрөнгө худалдагдсан тохиолдолд орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ. Энэ талаар “Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай” ТӨБЗГ-ын хуралдааны 2017 оны 252 дугаар тогтоолд тусгагдсан. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Нээлттэй дуудлага худалдааг 3 удаа зарласан боловч нэг ч оролцогч ирээгүй тул удааширч байна. |
| 33 | 47 | **Төрийн өмчит компани байгуулах тухай**<br>2017-04-12, № 117<br>2. Дараах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд П.Ганхүү, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц. Ням-Осор)-т даалгасугай: | **ТӨБЗГ – БТУХ**<br>ТӨБЗГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 132 дугаар тогтоолоор “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийг байгуулж, дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан. Мөн ТӨБЗГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 133 дугаар тогтоолоор “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлыг томилсон.<br>Дээрх шийдвэрийг үндэслэн ТӨБЗГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/63 дугаар тушаалаар “Эгийн голын | “Бүрэн хэрэгжсэн” - 100 %<br>Энэхүү тогтоолын заалтаар өгсөн үүрэг даалгавар бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2.1. “Эгийн голын усан цахилгаан станцын төсөл”-ийн техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо, судалгаанд тулгуурлан энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төрийн өмчит компанийг үүсгэн байгуулж, бүтэц, зохион байгуулалт, дүрмийг боловсруулж батлуулах.<br><br>2.2. Засгийн газрын 2013 оны 375 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжиж байгаа “Эгийн голын усан цахилгаан станцын төсөл”-ийн нэгжийн эд хөрөнгө болон Хөгжлийн банкнаас авсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг шинээр байгуулах “Эгийн голын усан цахилгаан станц” төрийн өмчит компанид балансаас балансад шилжүүлэн төрийн өмчид бүртгэх. | усан цахилгаан станц” ТӨХХК-ийн захирлын ажил хүлээлцүүлэх, эд хөрөнгийг тоолох Ажлын хэсэг байгуулагдан ажиллав. “Эгийн голын усан цахилгаан станцын төсөл”-ийн нэгжийн эд хөрөнгө болон Хөгжлийн банкнаас авсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-д балансаас балансад шилжүүлэн төрийн өмчид бүртгэх асуудлыг ТӨБЗГ-ын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 279 дүгээр тогтоолоор шийдвэрлэв. | | |
| 34 | 48 | **Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагыг өөрчлөн байгуулах тухай,**<br><br>2017-04-26, № 131<br><br>3. Монгол Улсын Их Сургуулийн балансад бүртгэлтэй байгаа Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль болон Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн байр, эд хөрөнгийг Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн балансад шилжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурьт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Их сургуулийн балансад бүртгэлтэй байгаа Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль болон Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн байр, эд хөрөнгийг Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн балансад шилжүүлэх Ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл томилогдон ажиллаж байна. МУИС-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5,771.3 сая төгрөгийн балансын үнэ, 2,441.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг өөрчлөн байгуулагдаж байгаа Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуульд балансаас балансад шилжүүлэх асуудлыг ТӨБЗГ-ын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 324 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Энэхүү тогтоолын заалтаар өгсөн үүрэг даалгавар бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 35 | 49 | **Төрийн өмчит компани байгуулах тухай (Ховд дулааны станц),**<br><br>2017-05-02, № 133<br><br>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>“Ховд дулааны станц” ТӨХК-ийн дүрмийг ТӨБЗГ-ын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 305 дугаар тогтоолоор, тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Энэхүү тогтоолын заалтаар өгсөн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | заасан төрийн өмчит компанийг зохих журмын дагуу үүсгэн байгуулж, бүтэц, зохион байгуулалт, дүрмийг боловсруулж батлуулахыг Эрчим хүчний сайд П.Ганхүү, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | хэрэгжүүлэх гишүүдийг мөн өдрийн 306 дугаар тогтоолоор, компанийн гүйцэтгэх захирлыг томилж, контракт байгуулах тухай ТУЗ-д өгөх удирдамжийг 307 дугаар тогтоолоор тус тус баталж, зохион байгуулалтын арга хэмжээ авав. | үүрэг даалгавар бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 36 | 50 | **Журам батлах тухай (Гадаадын арбитр болон гадаад улсын шүүхэд маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, маргаан үүссэн тохиолдолд баримтлах журам")**<br>2017-06-07, № 160<br>2. Гадаад улсын хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, маргаан үүсэх болон маргааныг шийдвэрлэх шатанд энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмыг баримталж ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга нарт болон төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлагад тус тус даалгаж, Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагын дарга нарт зөвлөмж болгосугай. | **ТӨБЗГ - БТУХ, ЗХЗХ**<br>Гадаад улсын хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, маргаан үүсэх болон маргааныг шийдвэрлэх шатанд энэхүү журмыг баримтлах талаар нийт албан хаагч, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд чиглэл өгч хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авав.<br>Одоогоор уг журмыг хэрэглэсэн тохиолдол гараагүй байна. | "Хэрэгжиж шатанд" – 70 % | |
| 37 | 51 | **Хөндлөнгийн хяналт тавих тухай,**<br>2017-06-20, № 177<br>1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлт гаргах үүрэг бүхий хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан хэрэгжилтэд нь | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн төлөөллийг оролцуулсан үнэлгээний хороо байгуулж, "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлт гаргах үүрэг бүхий хуулийн этгээдийг сонгон шалгаруулах олон улсын тендер зарласан. Тендерт олон улсын 5 байгууллага оролцсон бөгөөд Итали улсын "Кинетик Технoложи" компани шалгарсан бөгөөд уг компанитай гэрээ хэлэлцээр байгуулсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 %<br>Энэхүү тогтоолын заалтаар өгсөн үүрэг даалгавар бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | | | |
| | 52 | **Хөндлөнгийн хяналт тавих тухай,**<br>2017-06-20, № 177<br>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог зохих журмын дагуу хянаж шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>"Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлт гаргах үүрэг бүхий хуулийн этгээдээр шалгарсан Итали улсын "Кинетик Технологи" компанийн гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний зардал болох 335.6 мян.ам.долларын санхүүжилтийг "Эрдэнэс Монгол" ХХК-д хариуцуулахаар Засгийн газраас шийдвэрлэсэн. Энэтхэг улсын талаас газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ирүүлэх хугацаа болоогүй байгаа тул хөндлөнгийн хяналт тавих, дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээний санхүүжилт хийгдээгүй хүлээгдэж байна. | "Хэрэгжих шатанд" – 70 % | |
| 38 | 53 | **"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай,**<br>2017-07-04, № 202<br>1. ""Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эдгээр компанийн 49 хувийн энгийн хувьцааг төрд шилжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн талаар "Монголиан коппер корпорейшн" ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийн шүүхийн эцсийн шийдвэр гартал компанийг өөрчлөн зохион байгуулах асуудал нь эрх зүйн хувьд маргаантай, УИХ-ын 2017 оны 23 дугаар тогтоолын 3-т заасны дагуу "Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг Хөгжлийн банк болон Монголбанкнаас Худалдаа хөгжлийн банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө, ногдол ашиг, вексель зэрэг эх үүсвэрээс суутган тооцох хэлцэл хийх заалт хэрэгжээгүй байгаа. | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |
| | 54 | **"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай,** | **ТӨБЗГ – БТУХ**<br>"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн талаар "Монголиан коппер корпорейшн" ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийн шүүхийн эцсийн | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2017-07-04, № 202<br><br>2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаанаас Монгол Улсын иргэдэд хувь эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж, хувьцаа эзэмших хөтөлбөр батлан хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | шийдвэр гартал компанийг өөрчлөн зохион байгуулах асуудал нь эрх зүйн хувьд маргаантай.<br><br>УИХ-ын 2017 оны 23 дугаар тогтоолын 3-т заасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг Хөгжлийн банк болон Монголбанкнаас Худалдаа хөгжлийн банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө, ногдол ашиг, вексель зэрэг эх үүсвэрээс суутган тооцох хэлцэл хийх заалт хэрэгжээгүй байгаа тул Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаанаас Монгол Улсын иргэдэд хувь эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж, хувьцаа эзэмших хөтөлбөр батлах асуудал хэрэгжээгүй байна. | | |
| 39 | 55 | **Орон сууц хувьчлах тухай**<br><br>2017-08-09, № 218<br><br>2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 айлын 364 м.кв талбай бүхий орон сууцыг одоо эзэмшиж байгаа оршин суугчдад хувьчлах шийдвэрийг хэрэгжүүлэхээр Орон сууц хувьчлах тухай хуулийн 7, 17 дугаар зүйлийн дагуу материалыг хянан үзэж, хувьчлах зөвшөөрлийг Говь-Алтай аймгийн орон сууц хувьчлах товчоонд өгсөн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>ТӨБЗГ-аас хийх ажил бүрэн хийгдсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 40 | 56 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br><br>2017-08-09, № 219<br><br>1. Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 377,017,720.00 (гурван зуун далан долоон сая арван долоон мянга долоон зуун хорин) төгрөгийн балансын үнэтэй, 82,399,633.13 (наян хоёр сая гурван зуун ерэн есөн мянга зургаан зуун гучин гурван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн элэгдэл бүхий хавсралтад заасан дөрвөн барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Төрийн банкны 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 01/6041 дугаар албан бичгээр дуудлагын худалдаанаас олох орлогыг банкны орлогод үлдээх санал ирүүлсэн. Энэ тогтоолын 2 дахь заалтаар дуудлага худалдааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр заасан тул Төрийн банкны тавьж байгаа саналыг шийдвэрлэх боломжгүй юм.<br><br>Дуудлагын худалдааг зохион байгуулахаар бэлтгэж байна. | “Хэрэгжилт хангалтгүй” – 30 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | даалгасугай. | | | |
| | 57 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2017-08-09, № 219<br>2. Дуудлагын худалдааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Төрийн банкны гүйцэтгэх захирал Б.Цэндсүрэн нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Дуудлагын худалдаа зохион байгуулагдаагүй болно. | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |
| 41 | 58 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2017-08-17, № 229<br>2. Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал хэмнэх зорилгоор барилга хүлээлцэх ажлыг холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлж, чиглэл өгөн биелэлтийг тооцож ажиллав.<br>Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар хамтран дараах хөрөнгийг хүлээлцэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг иргүүлсэн:<br>- Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Жигүүр амралтын газрыг Гаалийн ерөнхий газарт шилжүүлсэн тухай;<br>- Говь-Алтай аймгийн Бургастай боомт дахь болон Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны барилгыг Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэх тухай.<br>Дорнод аймгийн МСҮТ, Дорнод аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний төв хамтран МСҮТ-ийн оюутны байрыг хүлээлцсэн.<br>БХБЯ, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар Говь-Алтай, Завхан аймгийн Газрын харилцаа, геодези зураг зүйн газарт тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах тухай албан бичиг хүргүүлсний дагуу хамтарсан ажлын хэсэг томилж, үл хөдлөх хөрөнгийг хүлээлцэх ажлыг зохион байгуулсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| 42 | 59 | **Орон сууц хувьчлах тухай**<br>2017-09-07, № 245<br>2. Орон сууц хувьчлах ажлыг | **ТӨБЗГ – БТУХ**<br>"Монголын төмөр зам" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдсан Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь "Шилжүүлэн ачих | "Бүрэн хэрэгжсэн" – 100 %<br>ТӨБЗГ-аас хийх ажил бүрэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга (Ц.Ням-Осор)-д даалгасугай. | цогцолбор-1”-ийн бүрэлдэхүүн хэсэг болох 60 айлын орон сууц (12 айлын орон сууц бүхий 5 барилга)-ыг одоо эзэмшиж байгаа оршин суугчдад нь хувьчлах зөвшөөрлийг ТӨБЗГ-ын 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А-1/2977 дугаар албан бичгээр Дорноговь аймгийн Орон сууц хувьчлах товчоонд өгсөн. Тус аймгийн Орон сууц хувьчлах товчооноос уг орон сууцыг эзэмшигчдэд нь хувьчилж, гэрчилгээ олгох ажлыг хийж гүйцэтгэв. | хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 43 | 60 | **Дотоодын цэргийн анги байгуулах тухай**<br>2017-09-25, № 280<br>2. Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын хамгаалалтын 2, 3 дугаар газрын бие бүрэлдэхүүн, барилга байгууламж, материал, техникийн хангамж, зэвсэг хэрэгслийг 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөр тасалбар болгон Дотоодын цэргийн штабт шилжүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэг гүйцэтгэгч С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>ТӨБЗГ-ын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 633 дугаар тогтоолоор дараах хөрөнгийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэв:<br>1. Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын хамгаалалтын 2 дугаар газар (хуучнаар)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 3,190.3 сая төгрөгийн балансын үнэ, 1,231.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий эд хөрөнгийг Дотоодын цэргийн 05 дугаар ангид балансаас балансад шилжүүлэх,<br>2. Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын хамгаалалтын 3 дугаар газар (хуучнаар)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,541.7 сая төгрөгийн балансын үнэ, 252.8 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий эд хөрөнгийг Дотоодын цэргийн 805 дугаар ангид балансаас балансад шилжүүлэх.<br>Тогтоолыг Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулав. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Тогтоолоор өгсөн үүрэг чиглэл бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 44 | 61 | **Хувьцааны хөрөнгө шийдвэрлэх тухай**<br>2017-10-25, № 300<br>2. ”Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцаа эзэмшигч “Кореа телеком” корпорациас хувьцаа худалдах талаар байгуулахаар санал болгож байгаа харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлд дурдсан төлбөрийн нөхцөлийг судлан хувьцааны төлбөрийг 2018 онд багтаан үе шаттайгаар барагдуулахаар хэлэлцээ хийхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням- | **ТӨБЗГ – БТУХ**<br>2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Засгийн газрын тогтоолыг “Кореа телеком” корпорацид албан бичгээр хүргүүлэн, уг тогтоолын хэрэгжилтийг хангахаар ТӨБЗГ-ын даргын тушаалаар Сангийн яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, ТӨБЗГ-ын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулсан.<br>Ажлын хэсэг “Кореа телеком” корпорациас 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ирүүлсэн гэрээний нөхцлийн талаарх саналтай танилцаад Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх болон гэрээний тэгш эрхийг хангах хүрээнд олон удаа санал өгсөн. Солонгосын тал ТӨЗБГ-ын саналын дийлэнх хэсгийг хүлээн авсан бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 7, 8-ны өдөр зохион байгуулагдсан БНСУ-ын “Кореа телеком” корпорацийн | “Бүрэн биелсэн” – 100 %<br>Тогтоолын заалтаар өгсөн үүрэг чиглэл бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Осор) болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад тус тус даалгасугай. | төлөөлөлтэй уулзах уулзалтын үеэр гэрээний үндсэн нөхцөлийг баталгаажуулсан.<br>2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулж, гэрээний дагуу талууд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | | |
| | 62 | **Хувьцааны хөрөнгө шийдвэрлэх тухай**<br>2017-10-25, № 300<br>3. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн менежментийг сайжруулан үйл ажиллагааг нь дэмжиж, үр ашигтай ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Харилцаа холбооны зохицуулах хороо (С.Адъяасүрэн), Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Энэ заалтын хэрэгжилтийг хангах үүднээс Ерөнхий сайдын захирамжаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон бусад холбогдох талуудын төлөөлөл бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсгээс Монгол Улсын Засгийн газар болон “Кореа телеком” корпораци хооронд байгуулсан “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”-г хэрэгжсэний дараа “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн менежментийг сайжруулах, үр ашигтай ажиллуулах талаар арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн. | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 45 | 63 | **Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай**<br>2017-11-24, № 315<br>2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт, хавсралтад заасан төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг хуульд заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус | **ТӨБЗГ – ХААХ**<br>Энэхүү тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 835,077.60 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 536 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулахаар батлагдсан.<br>Дээрх худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд нийт захиалагч буюу төсвийн ерөнхийлөн захирагч нартай хамтарсан төлөвлөгөөг батлуулахаар ТӨБЗГ-ын 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А-1/3494 дүгээр албан бичгээр төслийг хүргүүлж, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэв. | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тус даалгасугай. | | | |
| | | **ЗГТогтоол: 37 шийдвэрийн 49 заалт** | | | |
| **Долоо. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 46 | 64 | **Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах талаар авах арга хэмжээний тухай**<br>2014-01-11, № 02<br>5. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цахим дэлгүүр ажиллуулах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн программ хангамж, техникийн шийдэл, нөхцлийг ашиглан Цахим худалдан авах ажиллагааны системийг мэдээлэл солилцох төвлөрсөн сүлжээгээр дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн системтэй холбох ажлыг зохион байгуулахыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаа, Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Пүрэвдорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Ядамдорж, НДЕГ-ын дарга Ц.Уртнасан нарт тус тус даалгав. | **ТӨБЗГ – МТА**<br>Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем www.tender.gov.mn -ийг 2017 оноос бүх худалдан авах ажиллагааны захиалагч байгууллагууд ашиглаж байгаа бөгөөд “Мэдээлэл солилцоо” дэд системийн шийдлийг боловсруулсан. Энэхүү дэд системээр дараах төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцооны шуурхай, бодит байдлыг хангах асуудлыг шийдвэрлэж, тендер шалгаруулалтын ажилд ашиглаж байна. Тухайлбал, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас Үндэсний Дата төвөөр дамжуулан хуулийн этгээдийн талаарх мэдээллийг солилцох тухай 2016 онд байгуулсан №14/30 тоот гэрээний хүрээнд ажиллаж байна.<br>Сангийн яамны “Санхүүгийн тайлангийн е-баланс” системээс хуулийн этгээдийн борлуулалтын орлого, түргэн хөрвөх чадвар, санхүүгийн тайлан зэргийн талаарх мэдээллүүдийг, Татварын ерөнхий газрын татвар төлөгчийн мэдээллийн сангаас татварын үлдэгдэл болон үйл ажиллагааны борлуулалтын орлого, автомашины лавлагааг авах зэрэг мэдээллийг цахим хэлбэрээр солилцож байна.<br>Түүнчлэн төрийн байгууллагууд дундаас анх удаа Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлж, үндэсний тоон гарын үсгийн дэд системд холбогдон тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд уг гарын үсгийг ашиглан тендерт оролцох материалаа цахим хэлбэрээр баталгаажуулан ирүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br>Төрийн худалдан авах ажиллагаанд Үндэсний дата төвд байрлах төрийн мэдээлэл солилцооны систем болох “ХУР” системийг ашиглах гэрээ байгуулахаар холбогдох материалыг бэлтгэж, “Үндэсний дата төв” УТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудтай тохиролцов. Гэрээг 2018 оны 01 дүгээр сард байгуулахаар бэлтгэж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 47 | 65 | **Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах доод үнэ** | **ТӨБЗГ – БТУХ, ТӨБХХ**<br>Засгийн газрын 2001 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Худалдах доод үнэ тогтоох тухай” журмын дагуу төрийн өмчит | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **тогтоох талаар**<br>2015-02-02, № 07<br>ҮII. Засгийн газрын 2014 оны 195 дугаар тогтоолыг хүчингүй болгосонтой холбогдуулан төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах доод үнэ тогтоох ажлыг Засгийн газраас баталсан журмын дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тухай бүр зохион байгуулж, дуудлагын худалдаанаас олсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байхыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд тус тус даалгав. | хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах доод үнийг тогтоож, нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж байна. Уг журмыг энэхүү тэмдэглэлийн ҮII.3.2 дахь заалтаар шинэчлэн боловсруулахыг үүрэг болгосон.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулах тухай бүрд хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, доод үнийг тогтоосон дүгнэлт гаргуулж байгаа.<br>Засгийн газрын шийдвэрээр худалдах жагсаалтад багтсан 9 нэр бүхий объектийг 2015 онд нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж, 13.6 тэрбум төгрөгийн, 2016 онд 1 үл хөдлөх хөрөнгө буюу “Оргил рашаан сувилал” ТӨХК-ийн рашаан савлах байрыг түрээсийн давуу эрх тооцож, түрээсэлсэн ААН-д нь худалдаж, 242.8 сая төгрөгийн орлогыг тус тус төсөвт төвлөрүүлж байсан. 2017 онд “Архангай АЗЗА” ТӨХК-ийн “Замчин” зочид буудлыг 225.9 сая төгрөгөөр, Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын конторын хуучин барилгыг 47.0 сая төгрөгөөр, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн “Болор” амралтын газрыг 903.0 сая төгрөгөөр тус тус худалдаж, нээлттэй дуудлагын худалдааны нийт орлого 1,175.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.<br>“Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” ТӨБЗГ-ын 2016 оны 128 дугаар тогтоол баталж, зарим эрх зүйн зохицуулалт, дуудлага худалдааны үйл ажиллагааг тодорхой болгон мөрдүүлэв. Үүгээр хөдлөх хөрөнгийн доод үнийг хянаж, тогтоох асуудлыг ТӨБЗГ-ын хуралдаанаар шийдвэрлэхээр зохицуулсан.<br>2017 онд 89 байгууллагын 579 нэр төрлийн 5,139.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий эд хөрөнгийг худалдах шийдвэрийг гаргаж, 553.8 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн.<br>Ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөдлөх хөрөнгийн доод үнийг тогтоохдоо үлдэгдэл өртөг болон сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардал, чанарын бусад үзүүлэлтийг үнэлэн шийдвэрлэж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 48 | 66 | **Гарааны компани болон дундын үйлчилгээний лабораторийн тухай**<br><br>2015-03-02, № 43<br><br>XI.3. Гарааны компани болон дундын үйлчилгээний лабораторийг дээр дурдсан хугацаанд байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлээгүй тохиолдолд “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” улсын үйлдвэрийн газрыг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнтэй нэгтгэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлж, тус корпорацийн байрлаж байгаа байранд уг хүрээлэнг нүүлгэн байршуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд тус тус даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Эрдэм шинжилгээний байгууллагуудын үндсэн хөрөнгө, дэд бүтцийг хэвээр хадгалан, чиг үүргийнх нь дагуу ашиглуулах, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт үйлдвэрлэл, бизнесийн корпораци (хуучин нэрээр)-ийн байрлаж байсан байранд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнг нүүлгэн байршуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг тухайн үеийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд асан Л.Гантөмөр гаргасан болович тухайн үедээ тодорхой ажил хийгдээгүй болно.<br><br>Засгийн газрын 2016 оны 194 дүгээр тогтоолоор “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” улсын үйлдвэрийн газрын хөрөнгийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/08 дугаар тушаал гарсан. Ажлын хэсгээс тогтоолын хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах үүргийг ШУТИС-д өгсний дагуу тус сургуулийн захирлын 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/197 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, үл хөдлөх болон холбогдох бусад эд хөрөнгийг хүлээлцэн шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Засгийн газрын 2016 оны 194 дүгээр тогтоолын хүрээнд хэрэгжсэн.<br><br>Цаашид хяналтаас хасах саналтай байна. | Засгийн газрын дараах тогтоолууд хоорондоо холбоотой: 2015 оны 27, 2016 оны 194, 2017 оны 19. |
| 49 | 67 | **Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгасан зорилт, арга хэмжээг 2015 онд хэрэгжүүлсэн явцын тухай**<br><br>2016-03-28, № 18<br><br>XIX.3. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасан зорилт, арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br><br>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017, 2018 оны үндсэн чиглэлийг төсөлд тусгах саналыг боловсруулан батлуулахдаа “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-ийн 2 дугаар бүлгийн 2.4 дэх хэсгийн 1, 2 дугаар зорилтын хэрэгжилтийг хангахад чиглүүлэн төлөвлөж, бодлогын баримт бичгүүдийг уялдуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Аливаа бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэхэд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлэх ажлыг хэвшил болгож байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Хэрэгжилт нь тогтмолжиж хэвшсэн тул хяналтаас хасах саналтай байна. | |
| 50 | 68 | **Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 оны худалдан авах ажиллагааны тайлан, хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнгийн тухай** | **ТӨБЗГ - ХААХ**<br><br>1. ТӨБЗГ-т зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны тайланг холбогдох журамд заасны дагуу улирал бүр Сангийн | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2016-04-04, № 20<br><br>XXIII.2. Дараах арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:<br><br>1. Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, цаашид худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журам, зааврын дагуу хэрэгжүүлэх, 2015 оны үнэлгээгээр хангалтгүй дүн авсан албан тушаалтанд хариуцлага тооцож, дүнг 2016 оны 4 дүгээр сард багтаан Сангийн яаманд танилцуулах;<br><br>2. “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, худалдан авах ажиллагааны улирлын тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж байх;<br><br>3. Монгол Улсын төсвийн тухай хуулиар баталсан урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийг 2016 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор зарлан, мөн оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор тендер шалгаруулалтыг зохион байгуулж дуусган, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн байх;<br><br>4. Тендер шалгаруулалтын урилгыг олон нийтэд зарлан мэдээлэхдээ оролцогч аж ахуйн нэгжүүд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах боломжийг бүрдүүлэн ажиллах. | яаманд тус тус хүргүүлж хэвшсэн.<br><br>2. “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ын төсөлд өгөх саналыг нэгтгэн 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/14 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br><br>2017 онд нийт 50 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулахаас тендер зарласан 47 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх тооцох тухай, дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх тухай шаардлагыг тус тус тусгасан. Тайлант хугацаанд ТӨБЗГ-аас зарласан тендерт оролцогч 37 аж нэгж дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт ирүүлснийг тооцон ажилласан байна. Тендерт оролцогчдод олгосон дотоодын давуу эрхийг тооцсон талаар Сангийн яаманд хүргүүлсэн жил, улирлын тайланд тусгасан.<br><br>3. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолоор Худалдан авах ажиллагааны газар (татан буугдсан)-аас 2016 онд зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны жагсаалтыг баталсан. Уг жагсаалтад тусгагдсан худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг нь шинээр байгуулагдсан ТӨБЗГ-т шилжсэн. 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 37 төсөл, арга хэмжээ, Хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэх 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа буюу нийт 72.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 43 төсөл, арга хэмжээ, мөн Дэлхийн банкны “Ухаалаг засаглал” төслийн нэгжээс ажлын даалгавар, зураг, төсөв батлагдаж ирсэн 4 төсөл, арга хэмжээ, бусад яам, агентлагаас эрх шилжиж ирсэн 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Нийт 42.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсны үр дүнд 37.9 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулж, улсын төсөвт 4.7 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан. 2016 онд нийт зохион байгуулах худалдан авах ажиллагааны 63.0 хувийг бүрэн хэрэгжүүлсэн байна.<br><br>4. Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргаж болох боломж олгох зорилгоор зарлаж байгаа тендерийн баримт бичиг, урилгад энэ талаар тусгайлан зааж тусгах арга хэмжэ авч хэрэгжүүлсэн. | Хугацаа дуусч, дараагийн шийдвэр гарсан тул хяналтаас хасах саналтай байна.<br><br>2017 онд ТӨБЗГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт Засгийн газрын 2016 оны 152 дугаар тогтоолоор, 2018 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт 2017 оны Засгийн газрын 315 дугаар тогтоолоор тус тус батлагдсан болно. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 51 | 69 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай**<br><br>2016-08-17, № 41<br><br>III.1. Улсын төсвийн орлогын төлөвлөгөө тасарч, төсвийн зардлын эх үүсвэр хүрэлцэхгүй байгаатай холбогдуулан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж, 2016 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх, тэдгээрийн удирдлагын цалин, хөлс, урамшууллын хэмжээг зохистой түвшинд хүргэж бууруулах тухай асуудлыг хэлэлцээд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгав:<br><br>а) төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон удирдлагын цалин хөлс, урамшууллын хэмжээг өөрчилж, нэг сарын 5.0-10.0 сая төгрөгийн цалин хөлстэй этгээдийн цалин хөлсний хэмжээг 30 хувиар, 10.0 сая төгрөгнөөс дээш цалин хөлстэй этгээдийн цалин хөлсний хэмжээг 50 хувиар, 30.0 сая төгрөгнөөс дээш цалин хөлстэй этгээдийн цалин хөлсний хэмжээг 60 хувиар хувиар тус тус бууруулж, үр дүнгийн гэрээний биелэлт, байр, орон сууцны нөхцөлийг сайжруулах зэрэг үндэслэлээр их хэмжээний шагнал, урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж олгохыг зогсоох;<br><br>б) төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газруудын 2016 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийн дор дурьдсан зардлыг зогсоож, өвлийн бэлтгэл ажлыг хангах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 2016 оны төрийн өмчийн ногдол ашгийг төсөвт бүрэн төвлөрүүлэх:<br><br>-зарцуулагдаагүй цалин, хөлс, урамшуулал, | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2016 оны 69 дүгээр тогтоолын холбогдох заалт, Засгийн газрын хуралдааны 2016 оны энэхүү 41 дүгээр тэмдэглэл болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2016-12-06-ны өдрийн 1/744, 1/745 дугаар албан бичгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хүргүүлсэн "Албан даалгавар"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор үйлдвэрлэл санхүүгийн үр ашгийг дээшлүүлж, зардал бууруулан ажиллах зарчмыг баримтлан хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.<br><br>Энэхүү тэмдэглэлд тусгагдсан үндсэн болон нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын шимтгэл, томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, сургалтын зардал, бараа материал худалдан авах зардлын 2016 оны гүйцэтгэлийн дүнг төлөвлөгөөтэй харьцуулж дүгнэхэд 32.7 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан дүнтэй байна. Тэмдэглэлд заасны дагуу нэг сарын 5.0-10.0 сая төгрөгийн цалин хөлстэй 13 хуулийн этгээдийн удирдлагын цалинг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.<br><br>ТӨБЗГ-аас төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит 72 хуулийн этгээдийн эдийн засгийн үзүүлэлт 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр сайжирсан төлөвтэй байна. Тухайлбал, борлуулалтын орлого 2016 онд 1,555.1 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,797.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 15.6 хувиар буюу 242.8 тэрбум төгрөгөөр, цэвэр ашиг 2016 онд 1,105.2 сая төгрөгийн алдагдалтай байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3,442.7 сая төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 3 дахин буюу 4,547.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.<br><br>Нийт авлага 2016 онд 434.7 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 312.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 28.2 хувиар буюу 122.5 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 2016 онд 1,241.2 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,201.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3.2 хувь буюу 39.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг 13 компани, Төрийн банк, Хөгжлийн банкны дүн ороогүй болно.<br><br>Мөн урт хугацаат өр төлбөрийн дунд 9 хуулийн этгээдийн Хөгжлийн банкинд төлөх 1,054.6 тэрбум төгрөгийн өр төлбөр | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гадаад, дотоод томилолт, зочин, төлөөлөгч хүлээн авах болон сургалт, сурталчилгааны зардал;<br>-тавилга, эд, хогшил болон технологийн үйл ажиллагаанд шаардлагагүй бусад бараа, материал худалдан авах зардал;<br>-гэрээ байгуулаагүй буюу гэрээ байгуулсан боловч эхлээгүй бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал.<br>в) төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын цалин, хөлс, урамшууллын хэмжээг цаашид байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, ашигт ажиллагааны түвшинтэй уялдуулан зохистой байдлаар тогтоох ажлыг зохих журмын дагуу хариуцан зохион байгуулж шийдвэрлэх. | орсон бөгөөд нийт өр төлбөрийн 29.8 хувийг эзэлж байна.<br>2016 онд төрийн өмчит 38 хуулийн этгээд ашигтай ажиллаж байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 54 компани цэвэр ашигтай ажилласан, алдагдалтай ажилласан хуулийн этгээд 18 болж 2016 оныхоос 16-аар буурсан байна.<br>2016 онд төрийн өмчийн ногдол ашгийн 4.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн бол 2017 оны жилийн эцсийн байдлаар ногдол ашгийн 12.5 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 дахин, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот түвшинтэй харьцуулахад 1.6 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн өмч хувьчлалын орлого 16.8 тэрбум төгрөг, түрээсийн орлого 2.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлэв. | | |
| 52 | 70 | **Худалдан авах ажиллагааны тухай**<br>2016-09-28, № 48<br>XYII.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов. | **ТӨБЗГ – ХААХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 онд баталсан “Давуу эрх тооцох аргачлал” зэргийг мөрдлөг болгон ажиллах хүрээнд зохион байгуулж байгаа бүх тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх тооцох тухай заалтыг тусган холбогдох хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дотоодын давуу эрх тооцох аргачлалыг тодорхой болгох шаардлагатай байгаа тул 2007 онд Сангийн сайдын баталсан давуу эрх тооцох аргачлалын төсөлд тусгах санал боловсруулж, 2017 оны 01/14 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Тендерт оролцогч ААН-ээс тендер ирүүлэхдээ дотоодын давуу эрх тооцуулах хүсэлтээ гаргаж, хуульд заасан холбогдох баримт, материалыг ирүүлсэн тохиолдолд давуу эрхийг батлагдсан аргачлалын дагуу тооцон ажиллаж хэвшсэн.<br>Тайлант хугацаанд ТӨБЗГ-аас зарласан тендерт оролцогч 37 аж ахуйн нэгж дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт ирүүлснийг тооцон ажилласан байна.<br>Мөн импортыг орлох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэрүүдийг дэмжих, хамтарч ажиллах нөхцлийг бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилгоор 2017 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдөр “Тэнгэр плаза” худалдааны | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Засгийн газрын 2014 оны 18, 2015 оны 336, 396 дугаар тогтоолуудаар цаашид тайлагнах боломжтой тул хяналтаас хасах саналтай байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төвд “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага - 2017” өдөрлөг зохион байгуулсан. Тус өдөрлөгийн арга хэмжээнд 88 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ААН, 150 хувийн хэвшлийн аж ахуй нэгж оролцов. Өдөрлөгт оролцогч байгууллага, ААН үйлчилгээгээ нэг цэгээс иргэдэд хүргэж, бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлав. Энэ арга хэмжээний үеэр төр, хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн 12 санамж бичиг байгуулагдан, 148.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт хийгдэж, 10200 иргэн өдөрлөгийн үйл ажиллагаанд хамрагдсан. | | |
| | 71 | **Худалдан авах ажиллагааны тухай**<br>2016-09-28, № 48<br>XYII.2.6. Төсвийн байгууллагын байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.11-д заасны дагуу ерөнхий гэрээ байгуулан, мөн хуулийн $10^{1}$ дүгээр зүйл, 53.5.7-д заасны дагуу тус тус зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) болон бүх шатны төсвийн шууд захирагч нарт үүрэг болгов. | **ТӨБЗГ – ХААХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 152 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар ерөнхий гэрээгээр худалдан авах 4 төрлийн бүтээгдэхүүний жагсаалт батлагдсан. Эдгээр ажлуудын худалдан авах ажиллагаа “Ерөнхий гэрээ байгуулах журам”, тендерийн жишиг баримт бичиг шинэлчэгдэн батлагдаагүй байсан, тухайн төсвийн жилийн эхэнд зохион байгуулах шаардлагатай ажил учраас хэрэгжих боломжгүй байдалд хүрсэн.<br>Засгийн газрын 2017 оны 135 дугаар тогтоолоор батлагдсан 2018 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад тусгагдсан Эрүүл мэндийн сайдын багцаас худалдан авдаг ерөнхий нэршлийн зарим эмийг Сангийн сайдын 2017 оын 07 дугаар сарын 04-ний өдрийн 234 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын дагуу ерөнхий гэрээ байгуулан худалдан авахаар нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан, тендерийн нээлтийг 2018 оны нэгдүгээр сард хийнэ. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |
| 53 | 72 | **Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай**<br>2016-10-26, № 52<br>XIII.3.4. төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж байгаа байдалд тавих дотоод хяналт шалгалтыг сайжруулах арга хэмжээ | **ТӨБЗГ – БТУХ, ЗХЗХ**<br>Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой нийт 96 хуулийн этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ТӨБЗГ-аас 2017 оны А-1/391 дүгээр албан бичгээр чиглэл өгсөн.<br>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээг дүгнэхэд мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдлыг харгалзан дүгнэв. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад; | 2017 онд Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 95 хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн.<br><br>Дотоод аудитад хамрагдсан хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 86 хувьтай байгаагаас шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээ тайлангаа хуульд заасан хугацаанд 100 хувь оруулсан хуулийн этгээд 70 (77 хувь), мэдээллийг 30-50 хувь оруулсан хуулийн этгээд 5 (5 хувь), мэдээ тайлангаа хуульд заасан хугацаанд оруулаагүй хуулийн этгээд 7 (“Авто-Импекс” ХХК, “Эрдэнэс шивээ энержи”, ХХК, “Эрдэнэс ассет менежмент” ХХК, “Эрдэнэс Ашид” ХХК, “Эрдэнэс стийл” ХХК, “Гашуун сухайт авто зам” ХХК, “Оюу толгой” ХХК) байна.<br><br>Цаашид шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлэх, мэдээ тайлангаа хуульд заасан хугацаанд бүрэн оруулах, байгууллагын өөрийн цахим хуудас дахь шилэн дансны цэсээ тогтмол шинэчлэн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллах талаар ТӨБЗГ-ын даргын 2018 оны А-1/336-347 дугаар албан бичгийг “Эрдэнэс-Монгол” ХХК, “Авто-Импекс” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨХХК, “Хөгжлийн банк” ХХК, “Буянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨХХК, “Геологийн судалгааны төв” ТӨҮГ, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ, “Монгол ус” ТӨҮГ-т тус тус хүргүүлсэн. | | |
| 54 | 73 | **Үрийн төрөлжсөн аж ахуй байгуулах тухай**<br><br>2016-11-16, № 55<br><br>XXҮI.6. Дарханы ургамал, газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэн болон үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжтэй хамтран үрийн төрөлжсөн аж ахуй байгуулах асуудлыг судалж танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт; | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Тайлбар: Дарханы ургамал, газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэн болон үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжтэй хамтран үрийн төрөлжсөн аж ахуй байгуулах асуудлаар ХХААХҮЯ, БСШУСЯ бодлогын түвшинд судалж, санал боловсруулан шийдвэрлүүлсний дараа төрийн өмчийн асуудлыг зохицуулах боломжтой. | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – ХБ. | ТӨБЗГ-аас шууд хамаарч шийдвэрлэх асуудал биш тул хүлээгдэж байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 74 | **Төсвийн зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай**<br>2016-11-16, № 55<br>XXIY.2. Татан буугдсан "Биобэлдмэлийн үйлдвэр" ТӨААТҮГ-ын үндсэн болон эргэлтийн хөрөнгөд тооллого хийж балансаас балансад шилжүүлэх, хаалтын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргах зэрэг ажлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэгт даалгав. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Эрүүл мэндийн сайдын 2017 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн А/85 тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан татан буугдсан "Биобэлдмэлийн үйлдвэр" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын чиг үүргийг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнд шилжүүлэн "Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв" байгуулж, Засгийн газрын 2016 оны тогтоолыг хэрэгжүүлж байна. Ажлын хэсэг хөрөнгийг тооллогыг хийсэн, эргэлтийн болон эргэлтийн бус нийт 140.0 сая төгрөгийн хөрөнгө тоологдсон. Өр авлагын судалгааг гарган, хаалтын баланс гаргахад хийсэн. Гэвч хөрөнгө шилжүүлэх ажил хийгдээгүй байгаа, ЭМЯ-аас эцэслэн шийдвэрлэх арга хэмжээ аваагүй хүлээгдэж байна. | "Хэрэгжих шатанд" – 70 % | ТӨБЗГ-аас шалтгаалаагүй. |
| 55 | 75 | **Монгол Улсад байгаа ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлын тухай**<br>2016-11-30, № 58<br>Y.2. Монгол Улсад байгаа ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлаар Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт тусгагдсан зарчмын дагуу оросын талтай хэлэлцээ хийж, явцыг Засгийн газарт танилцуулж байхыг Ажлын хэсэг (Ц.Ням-Осор)-т даалгав. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Тайлант хугацаанд, Засгийн газар хоорондын 1971 оны протокол, 1979 оны хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд харилцан солилцох ноот бичгийн төслийг ОХУ-ын талтай зөвшилцөж, хоёр улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхтэй холбоотой баримт материалыг бүрдүүлэх ажлыг гүйцэтгэв. Энэ хүрээнд ОХУ-ын төлөөлөгчид 2017 оны 03 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд Монгол улсад ажиллах үеэр хийсэн хамтарсан хуралдаанаар зөвшилцсөний дагуу ОХУ-ын талд ноот бичгийг ГХЯ-наас хүргүүлсэн, хариу ирэхийг хүлээж байна.<br>Монголын талын Ажлын хэсэг холбогдох байгууллагуудтай 6 удаагийн уулзалт хийж, хэлэлцээг үр дүнтэй болгох бүх талын арга хэмжээг авч байна.<br>Мөн ОХУ-ын талаас ирсэн шинжээчидтэй хамтран ажиллаж холбогдох үл хөдлөх хөрөнгийн жагсаалт, кадастрын зураг, хаяг авах ажлыг зохион байгуулан хийсэн. Эдгээр байртай холбоотой төрийн байгууллага болон иргэдийн албан бичигт хариу өгөх, шаардлагатай судалгаа, танилцуулгыг бэлтгэж, албан бичгээр хүргүүлэх ажлыг гүйцэтгэв. | "Хэрэгжих шатанд" – 70 %<br>Ерөнхий сайдын 2016 оны 91 дүгээр захирамжийн 2 дугаар заалттай утга нэг байгаа тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | ТӨБЗГ-аас шууд хамаарахгүй. |
| 56 | 76 | **Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгийн тухай**<br>2016-12-21, № 61 | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Ерөнхий сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны 56 дугаар захирамжаар ОХУ-ын Москва хотод байгаа Элчин сайдын яамны 2-р байрны ашиглалтыг газар дээр нь шалгах хэрэгжилтийг хянах чиглэлээр ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг ГХЯ-ны | "Хэрэгжих шатанд" – 70 % | ТӨБЗГ-аас шууд хамаарахгүй. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2. Оросын Холбооны Улсын Москва хот дахь Элчин сайдын яамны 2 дугаар байр болон Улаан-Үд хот дахь Консулын газрын барилгад хөрөнгө оруулалт хийсэн маргаантай асуудал, Монгол Улсаас Бельгийн Вант Улсад суугаа Элчин сайдын яамыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлыг судалж, тулгамдсан асуудал, маргааныг шийдвэрлэх талаар санал боловсруулан танилцуулахыг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт тус тус даалгав. | Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэнгээр ахлуулан байгуулсан. Уг ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажиллаж, холбогдох материалыг судалж байна. Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, хийх ажлын төлөвлөгөөг батлан түүний дагуу ажиллаж байна. Шинжээчдийн Ажлын хэсэг Москва хотод 6 дугаар сарын 7-14-ний өдрүүдэд ажиллаж, 2008-2017 оны эхний хагас жил хүртэлх хугацааны түрээсийн тооцоо, ашиглалтын зардлын тооцоог хийж, хөрөнгө оруулалтын тооцоог нийлэх асуудлаар ОХУ-ын “Центррегионэстент” компанид санал боловсруулж хүргүүлэв. Газар дээр нь ажиллаж, холбогдох материалыг шалган хянасан тайланг бэлтгэн баталгаажуулж ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. Маргаантай асуудлын талаарх хэлэлцээг үргэлжлүүлж байна.<br><br>Бусад Дипломат төлөөлөгчийн газрын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлыг шийдвэрлэх Ажлын хэсэг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 230 дугаар тушаалаар томилогдож, уг ажлын хэсэгт мөн ТӨБЗГ-ын төлөөлөл ажиллаж байна.<br><br>Маргаантай байгаа үл хөдлөх хөрөнгийн танилцуулга, хөрөнгө оруулалтын холбогдох материалтай Ажлын хэсэг танилцсан бөгөөд нэмэлт материал цуглуулахаар тогтож, Дипломат төлөөлөгчийн газруудад ГХЯ-наас мэдэгдэл хүргүүлсэн байна. | | |
| | 77 | **Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгийн тухай**<br><br>2016-12-21, № 61<br><br>2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнг Улсын Их Хуралд танилцуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт тус тус даалгав. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын дүнг Засгийн газарт танилцуулж, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаар тогтоолоор төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээг шийдвэрлэсэн. Тооллогын танилцуулгыг ЗГХЭГ-т дэвтэрлэж өгч, танилцуулав.<br><br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 126 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” хууль тогтоомжийн төслийг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уг хууль тогтоомжийн төслийг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн болович Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор буцаагдсан. Боловсруулалтад нэмэлт өөрчлөлт оруулж, ЗГХЭГ-т хүргүүлээд байна. Энэхүү хууль тогтоомжийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх хүрээнд үзлэг, тооллогын дүнг танилцуулахаар бэлтгэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 57 | 78 | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**<br>2017-01-04, № 01<br>YII.2. Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийн сонгон шалгаруулалтыг 2017 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор зарлаж, тендерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж 4 дүгээр сарын 1-ний өдрөөс ажлыг нь эхлүүлсэн байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгав. | **ТӨБЗГ – ХААХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 78.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 30 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулж байна.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас 8, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 9, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын багцаас 1, Эрүүл мэндийн сайдын багцаас 4, Зам, тээврийн хөгжлийн сайдын багцаас 2, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх тус тус шилжиж ирсэн.<br>Мөн Дэлхийн банкны санхүүжилтээр ЗГХЭГ-ын хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг төсөл”-ийн 7, Азийн хөгжлийн банкны 5, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. 2017 онд ТӨБЗГ-т нийт дүнгээр 68 төсөл, арга хэмжээний 109 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд явцыг дор танилцуулбал:<br>1. Гэрээ байгуулсан - 61 багц ажил;<br>2. Гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн - 3 багц ажил;<br>3. Захиалагчид буцаасан - 9 багц ажил;<br>4. Тендер зарласан, нээлт хийх болоогүй - 8 багц ажил;<br>5. Тендерийн нээлт хийсэн, үнэлгээ хийж буй – 16 багц ажил,<br>6. Техникийн тодорхойлолт ажлын даалгавар ирүүлээгүй – 3 багц ажил;<br>7. Хүчингүй болсон - 3 багц ажил;<br>8. Захиалагчид зөвлөмж хүргүүлсэн – 1 багц ажил;<br>9. Үнэлгээний хороо байгуулагдсан, тендерийн баримт бичиг боловсруулж байгаа – 5 багц ажил.<br>Нийт дүнгээр, 68 төсөл, арга хэмжээний 109 багц ажлын худалдан авах ажиллагааны 71.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 26.0 хувь нь хэрэгжиж байгаа, 3.0 хувь нь захиалагчаас ажлын даалгавар ирээгүйн улмаас хэрэгжүүлэх боломжгүй байна. | “Хэрэгжих шатанд” – 70 %<br>Цаашид Засгийн газрын 2016 оны 152 дугаар тогтоолын хэрэгжилтээр тайлагнах боломжтой, мэдээлэл давхардаж байгаа тул хяналтаас хасах саналтай байна.<br>Мөн цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон. | ТӨБЗГ-аас шууд хамаараагүй. Захилагч байгууллагаас ТӨБЗГ-т ирүүлэх материал удааширч ирсэн, бусад байгууллагаас 5, 6 –р сард эрх шилжиж ирсэн ажлуудтай холбоотой. |
| | 79 | **Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны талаар болон өөрийн эрхлэх ажлын хүрээнд хийж, гүйцэтгэх ажлыг мэдээлэх тухай** | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br>Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны талаар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхлэх асуудлын хүрээнд 2017 онд байгууллагын цахим хуудас, | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2017-01-04, № 01<br><br>3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гаргасан хуваарийн дагуу Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны талаар болон өөрийн эрхлэх ажлын хүрээнд хийж, гүйцэтгэх ажлыг 14 хоног, сар, улирал бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тогтмол мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | олон нийтийн цахим сүлжээнд 102 мэдээ, мэдээлэл, 14 дуудлагын худалдааны зар байршуулсан. Олон нийтэд 106 мэдээ мэдээлэл, телевизийн 38 тодруулга ярилцлага, телевизийн 7 нэвтрүүлэгт холбогдох албан хаагч оролцож, мэдээ мэдээлэл нийтлүүлсэн. Нийт 252 цахим хуудас, 187 телевиз, 65 өдөр тутмын сонин, 6 радиотой хамтран ажиллаж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг нийтлэн нэвтрүүлж, сурталчилсан.<br><br>Мөн “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага - 2017” өдөрлөгийн хүрээнд “Сайн засаглал” телевизийн нэвтрүүлэг бэлдэж, МҮОНТ-ээр нэвтрүүлсэн. Түүнчлэн, www.youtube.com суваг-т байршуулсан. “Сайн засаглал” сэтгүүл хэвлүүлж олон нийтэд хүргэсэн.<br><br>Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах хүрээнд тус газрын “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ыг боловсруулан ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/169 дүгээр тушаалаар батлан мөрдүүлж байна. | | |
| 58 | 80 | **Төрийн өмчийн хуулийн этгээдүүдийг татан буулгах асуудлын тухай**<br><br>2017-01-25, № 04<br><br>IY. “Монгол тариалан корпораци”, “Монгол мах корпораци”, “Аж үйлдвэрийн цогцолбор” төрийн өмчийн хуулийн этгээдүүдийг татан буулгах асуудлыг хэлэлцээд газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, махны нөөц бүрдүүлэх ажлыг “Монгол тариалан корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Монгол мах корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газруудаар гүйцэтгүүлэх боломжийг судлан үзэж, татан буулгах гэж байгаа зарим байгууллагын өр, төлбөрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж, Засгийн газрын дараагийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Үйл ажиллагаа нь зогссон “Монгол тариалан корпораци” ТӨҮГ, “Монгол мах корпораци” ТӨҮГ, “Монгол тамга” ТӨҮГ, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийг татан буулгах асуудлыг судалж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасны дагуу эдгээр төрийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах асуудлаар холбогдох яамны саналыг тусгасан үндэслэл санал боловсруулж, шийдвэрлүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |
| 59 | 81 | **Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2016 оны жилийн эцсийн дүнгийн тухай** | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br><br>2017 оны эхний хагас жилд нийт УИХ, Засгийн газрын 29 шийдвэрийг шинээр хяналтад бүртгэн авч, хэрэгжүүлэх ажлыг | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Хэрэгжилт нь | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2017-03-07, № 11<br><br>XYI.1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:<br><br>1. Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөтэй шуурхай зохион байгуулах; 2. Үүрэг болгосон шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” (www.unelgee.gov.mn)-д байршуулж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв хийж тайлагнах; 3. 2016 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг, даалгаврыг биелүүлэх талаар онцгой анхаарч, хэрэгжсэн, хэрэгжилт нь тогтмолжсон ажлыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем /www.unelgee.gov.mn/-д тэмдэглэл хийж, хяналтаас хасуулах; 4. Хууль тогтоомжид заасан эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх. | зохион байгуулалтаар хангаж ажиллав. 2016 оны жилийн эцсийн дүнгээр удаашрсан заалтуудыг хэрэгжүүлэх талаар анхааран, холбогдох мэргэжилтнүүдэд зөвлөмж, чиглэл өгөв. Тайлант хугацаанд, дээд шатны байгууллагын нийт 6 төрлийн 51 шийдвэрийн 68 заалтын хэрэгжилтийн 2017 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн боловсруулж, ХШҮ хийж, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ЗГХЭГ-т тайлагнасан. Тайланг ТӨБЗГ-ын цахим хуудас болон “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” www.unelgee.gov.mn -д байршуулан олон нийт, хэрэглэгчид мэдээлсэн.<br><br>2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 8 төрлийн 70 шийдвэрийн 102 заалтын хэрэгжилтийг тайлагнаж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулахаар бэлтгэж байгаа.<br><br>Тайлант хугацаанд, Захиргааны ерөнхий хуулийн дагуу хууль тогтоомжид заасан 6 эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг Засгийн газраас томилсон орон тооны бус гишүүдийг оролцуулсан ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолоор батлуулан мөрдүүлж байна. | тогтмолжиж, хэвшсэн тул хяналтаас хасах саналтай байна. | |
| 60 | 82 | **““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх тухай**<br><br>2017-03-29, № 14<br><br>X. ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлт удааширч байгааг харгалзан дээрх компаниудын | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн ХЭГ/479, ХЭГ/500 дугаар албан бичгээр өгсөн чиглэлийг үндэслэн ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/50 дугаар тушаалаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд төрийн өмчийг төлөөлөн оролцох төлөөлөгчдийг томилж, удирдамж баталсан. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хуралдуулан, дүрмийн зарим заалтыг өөрчлөн найруулах тухай болон тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх, шинээр томилох шийдвэрийг гаргасан. Шинээр томилогдсон ТУЗ-д ТӨБЗГ-ын А-1/166 дугаар албан бичгээр удирдамж өгсний дагуу | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Тухайн тэмдэглэлээр өгсөн үүрэг тухайн үедээ хэрэгжсэн гэж үзэж хяналтаас хасах саналтай байна. | Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс энэхүү тэмдэглэлийн “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай холбоотой хэсгийг хууль бус гэж шийдвэр гаргасан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөөлөн удирдах зөвлөлийг 100 хувь төрийн төлөөллөөр бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт даалгав. | 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр ТУЗ нь хуралдаж, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, бүтэц, орон тоог шинэчлэн батлах шийдвэр гаргасан.<br>“Монголиан коппер корпрейшн” компанийн нэхэмжлэлд нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 128/ШШ 2017/0453 дугаар бүхий шийдвэр гаргасан. Уг шүүхийн шийдвэрээр Засгийн газрын хуралдааны энэхүү тэмдэглэл, ЗГХЭГ-ын дээр дурдсан албан бичгүүдээр өгсөн чиглэлийг тус тус илт хууль бус захиргааны актад тооцож, ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/50 дугаар тушаал, А-1/166 дугаар албан бичгийг тус тус хүчингүйд тооцсон. Үүгээр энэхүү тэмдэглэлээр өгсөн үүргийг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон боловч ТӨБЗГ-ын зүгээс тэмдэглэлээр даалгасан үүргийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.<br>“Монголросцветмет” ХХК-ийн талаар Засгийн газраас тодорхой чиглэл ирүүлээгүй байна. | | |
| 61 | 83 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн тухай**<br>2017-05-17, № 22<br>XIY.2. Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилтийн явц байдлын талаар УИХ-ын холбогдох Байнгын хороонд мэдээлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Улсын Их Хурлын 2017 оны “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд ТӨБЗГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх танилцуулга, мэдээллийг боловсруулан Хууль зүйн байнгын хорооны гишүүдэд танилцуулсан. Уг хуралдаанд ТӨБЗГ-ын дарга удирдлага оролцсон. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Цаашид хяналтаас хасах саналтай. Энэхүү маргаантай асуудал шүүхээр хэлэлцэгдэж байгаа, Засгийн газраас дараагийн шийдвэр гарсан, тухайн цаг үед энэ тэмдэглэлээр өгсөн үүрэг биелсэн. | Шүүхийн маргаантай асуудал. |
| 62 | 84 | **Дэд станцад гарсан ослын тухай.**<br>2017-06-07, № 27<br>XI.1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд П.Ганхүү, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгав: | **ТӨБЗГ - БТУХ**<br>Өмнөд 110/10/6 кВ-ын дэд станцад 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдөр гарсан аваарийн нөхцөл байдлыг арилгахад удирдлага, зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ аваагүй, осол, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хангалтгүй ажиллаж хэрэглэгчдийг эрчим хүчээр тасалдуулан системийн найдвартай ажиллагааг алдагдуулахад хүргэсэн “ДҮТ” ХХК, | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Тэмдэглэлийн заалтаар өгсөн үүрэг бүрэн биелсэн тул цаашид | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1. Өмнөд 110/10/6 кВ-ын дэд станцад 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдөр гарсан ааварийн нөхцөл байдлыг арилгахад удирдлага, зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ аваагүй, осол, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хангалтгүй ажиллаж хэрэглэгчдийг эрчим хүчээр тасалдуулан системийн найдвартай ажиллагааг алдагдуулахад хүргэсэн “ДҮТ” ХХК, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, “Улаанбаатарын түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал болон холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх; 2. Ааварийн улмаас үүссэн хохирлыг богино хугацаанд арилгах арга хэмжээ авч, эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч явц, үр дүнг танилцуулж байх. | “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, “Улаанбаатарын түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал болон холбогдох инженер, техникийн ажилтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд удирдамжаар үүрэг өгч, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө гарган биелэлт үр дүнг тооцож байна.<br><br>“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, “Улаанбаатарын түгээх сүлжээ” ТӨХК болон эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч явц, биелэлт үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тайланг ТӨБЗГ-т хүлээн авч дүгнэв. | хяналтаас хасах саналтай байна. | |
| 63 | 85 | **“Кореа телеком” корпорацийн саналын тухай**<br><br>2017-07-18, № 34<br><br>I.2. Хувьцааг худалдан авах нөхцөл, хугацаа, үнийн талаар “Кореа телеком” корпорацитай хэлэлцээ хийж, явц дүнг Засгийн газарт танилцуулж байхыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт даалгав. | **ТӨБЗГ - БТУХ**<br><br>2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан “1995 оны 8 дугаар сарын 31-нд Монгол Улсын Засгийн Газар ба “Кореа телеком” корпораци хоорондын “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцааг худалдах тухай” гэрээний 1 дүгээр хавсралтын дагуу “Кореа телеком” корпораци нь “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 40 хувь (10,348,110.0 ширхэг)-ийн хувьцааг Монгол Улсын Засгийн газарт 2,550,000.0 ам.доллараар худалдах саналыг албан ёсоор ирүүлсэн. Монгол Улсын засгийн газрын хуралдаанаар энэ асуудлыг хэлэлцээд хувьцааг худалдан авах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасныг “Кореа телеком” корпорацийн талд мэдэгдсэн.<br><br>2017 оны 07 дугаар сарын 25, 8 дугаар сарын 18-ны өдрүүдэд “Кореа телеком” корпорацийн зүгээс монголын талтай уулзаж, санамж бичиг байгуулах, хувьцаа худалдан авах гэрээ (SPA)-ний гол заалтуудын талаар зөвшилцөх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор “Кореа телеком” корпорацийн төлөөлөлтэй биечлэн уулзах болон албан бичгээр харилцаж, хувьцаа | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Энэ тэмдэглэлээс хойш Засгийн газрын дараачийн шийдвэр гарсан тул цаашид хяналтаас хасах саналтай байна.<br><br>Тухайлбал, Засгийн газрын хуралдааны 2017 оны 39 дүгээр тэмдэглэл, Засгийн газрын 2017 оны 300 дугаар тогтоол гарсан болно. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | худалдан авах төлбөр болон хувьцаа шилжүүлэх зэрэг ажлын үндсэн нөхцөлүүдийг тохирч, улмаар Засгийн газрын хуралдаанд тогтоолын төсөл оруулсан. | | |
| 64 | 86 | **Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2017 оны хагас жилийн дүнгийн тухай**<br>2017-08-09, № 35<br>Дараах арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:<br>4. Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нь даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу тогтоосон хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсны үндсэн дээр тайлагнах, "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем" /www.unelgee.gov.mn/-д байршуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт; 5. 2017 оны хагас жилийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа шийдвэрийг заалт тус бүрээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт. | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр ТӨБЗГ-ын эрхлэх асуудлын хүрээнд даалгасан заалт бүрийг хяналтад авч хэрэгжүүлэн хэрэгжилтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн тайлагнахаар бэлтгэж байна. Нийт 8 төрлийн 70 шийдвэрийн 101 заалтын хэрэгжилтийг нэгтгэж, ХШҮ-ийн тайланг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Дээд шатны байгууллагын шийдвэрийн 2017 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дүнгийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг хэлтэс, албан хаагчдын дунд зохион байгуулалтаар ханган ажиллаж, Даргын зөвлөлийн хурлын шийдвэр, ХШҮ-ний дүгнэлт, зөвлөмжийг хэлтэс, албан хаагчдад таниулах арга хэмжээ авав. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| 65 | 87 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2017-08-17, № 36<br>III.2. Яам, Засгийн газрын агентлаг, төсөвт байгууллагын харьяанд ажилладаг амралтын газрын талаар болон төсвөөс санхүүжүүлдэг амралтын газрыг худалдах, хувьчлах саналаа | **ТӨБЗГ – БТУХ**<br>Яам, Засгийн газрын агентлаг, төсөвт байгууллагын харьяанд ажилладаг амралтын газар болон төсвөөс санхүүжүүлдэг амралтын газар, түүний хөрөнгийн бүртгэл, санхүүжилтийн талаар судалж байна. Тус ажил судалгааны шатанд явж байгаа болно. | "Хэрэгжилт хангалтгүй" – 30 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт даалгав. | | | |
| | 88 | **Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах, үйл ажиллагаагэхлүүлэхэд тулгамдаж байгаа асуудлын тухай**<br>2017-08-17, № 36<br>7.3. “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын менежемент төсөл”-ийг хэрэгжүүлэх компанийн монголын болон японы талуудын эзэмших хувь, монголын талын эзэмших хувьд оролцох этгээдийн эзэмших хувь хэмжээг тус тус тодорхойлж, саналаа Засгийн газарт танилцуулахыг Ерөнхий сайдын 2017 оны 16 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн дарга бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Засгийн газрын 2017 оны 322 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын менежемент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн япон талд ногдох хувийг 51, монголын талд ногдох хувийг 49 байхаар тогтоосон. Монголын талд ногдох хувийг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал ТӨААТҮГ-т эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. | “Бүрэн биелсэн” – 100 %<br>Засгийн газрын тогтоол батлагдаж, тэмдэглэлийн заалтаар өгсөн үүрэг бүрэн биелсэн тул хяналтаас хасах саналтай байна. | |
| | 89 | **Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах, үйл ажиллагаагэхлүүлэхэд тулгамдаж байгаа асуудлын тухай**<br>2017-08-17, № 36<br>7.4. Агаарын хөлгийн шатахуун хангамжийн гидрант системийн үйл ажиллагааны схемийг тодорхойлж, шатахуун хангамжийн үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг судалж шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Зам, тээврийн хөгжлийн яамнаас мэргэжлийн түвшинд шийдвэрлэх шаардлагатай. ТӨБЗГ-аас шууд хамаарахгүй. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 66 | 90 | **“Иргэд, олон нийттэй харилцах төв”-д** | **ТӨБЗГ – ЗХЗХ**, бүх хэлтэс | “Бүрэн хэрэгжсэн” | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай**<br><br>2017-08-23, № 37<br><br>Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс 2017 оны эхний хагас жилд “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. | 2017 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-өөр дамжуулан нийт 24 иргэн хандаж санал, хүсэлт, гомдол, ирүүлснийг хүлээн авч, бүртгэлд хамруулан шийдвэрлэж ажиллав.<br><br>2017 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 170 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авч, байгууллагын дотоод сүлжээ www.able цахим системд бүртгэн, удирдлагын заалтын дагуу албан хаагчид хуваарилан шийдвэрлүүлсэн. Ирсэн өргөдөл, гомдлын 149 нь шийдвэрлэгдэж, 21 нь шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн тухай хариуг хуулийн хугацаанд өгч ажиллав.<br><br>Иргэдээс ТӨБЗГ-т ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг Даргын зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулан, хурлын тэмдэглэлээр хэлтэс, албан хаагчдад үүрэг, чиглэл өгч, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх талаар авах арга хэмжээг тодорхой болгов. | – 100 % | |
| 67 | 91 | **“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч “Кореа телеком” корпорацийн эзэмшлийн хувьцаар Засгийн газар худалдан авахтай холбоотой санхүүжилтийн тухай**<br><br>2017-09-13, № 39<br><br>XXII.1.2. ”Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч “Кореа телеком” корпорациас хувьцаар худалдах талаар ирүүлсэн харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлд дурдсан төлбөрийн нөхцөлийг судлан хугацааг сунгах талаар хэлэлцээ хийж, хувьцаар худалдан авах төлбөрийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар тодорхой санал боловсруулж танилцуулахыг | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>“Кореа телеком” корпорацийн зүгээс монголын талтай уулзаж, санамж бичиг байгуулах, хувьцаа худалдан авах гэрээ (SPA)-ний гол заалтуудын талаар зөвшилцөх хүсэлтэй байгаагаа илэрхийлсний дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас солонгосын талын төлөөлөлтэй биечлэн уулзах болон албан бичгээр харилцаж, хувьцаа худалдан авах төлбөр болон хувьцаа шилжүүлэх зэрэг ажлын үндсэн нөхцөлүүдийг тохирч, улмаар Засгийн газрын хуралдаанд тогтоолын төсөл оруулсан.<br><br>Тухайлбал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А-1/3022 дугаар албан бичгээр харьцаж, Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль нэгэнт батлагдсан, уг хуульд хувьцаа худалдан авах хөрөнгийн эх үүсвэр тусгагдаагүй тул хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой болсон нөхцөлд харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлд дурдсан төлбөрийн нөхцөл, хугацааг сунгах асуудлыг | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Энэ тэмдэглэлээс хойш Засгийн газрын дараачийн шийдвэр гарсан тул цаашид хяналтаас хасах саналтай байна.<br><br>Засгийн газрын 2017 оны 300 дугаар тогтоол гарсан, цаашид энэ тогтоолын хэрэгжилтээр тайлагнах | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгав. | хэлэлцээрийн замаар шийдвэрлэх тухай тохирсон.<br>2017 оны 12 дугаар сарын 07, 08-ны өдөр БНСУ-ын “Кореа телеком” корпорацийн талтай уулзалт зохион байгуулж, гэрээний үндсэн нөхцөлийг баталгаажуулсан. 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулж, гэрээний дагуу талууд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | боломжтой. | |
| | 92 | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**<br>2017-09-13, № 39<br>XXII.2.1. 2017 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль тогтоомжийн дагуу дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчийг давуу эрхээр шалгаруулж байгааг сайшаан, цаашид дотоодын аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов | **ТӨБЗГ – ХААХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 онд баталсан “Давуу эрх тооцох аргачлал” зэргийг мөрдөж, ТӨБЗГ-т зохион байгуулж байгаа бүх тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх тооцох тухай заалтыг тусган холбогдох хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дотоодын давуу эрх тооцох аргачлалыг тодорхой болгох шаардлагатай байгаа тул давуу эрх тооцох аргачлалын төсөлд тусгах санал боловсруулж, 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/14 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Тендерт оролцогч ААН-ээс тендер ирүүлэхдээ дотоодын давуу эрх тооцуулах хүсэлтээ гаргаж, хуульд заасан холбогдох баримт, материалыг ирүүлсэн тохиолдолд давуу эрхийг батлагдсан аргачлалын дагуу тооцон ажиллаж хэвшсэн.<br>Тайлант хугацаанд, ТӨБЗГ-аас зарласан тендерт оролцогч 37 аж нэгж дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт ирүүлснийг тооцон ажилласан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 93 | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**<br>2017-09-13, № 39<br>XXII.2.2. Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | **ТӨБЗГ – ХААХ**<br>Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараас энэхүү тэмдэглэлийн заалтын дагуу ирүүлээгүй байна. ТӨБЗГ нь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://tender.gov.mn –ийн үйл ажиллагааг эрхлэн хариуцдаг тул цахим системийн мэдээллийг хянах замаар худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг уг системд байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа байдалд хяналт тавин ажиллаж байна.<br>21 аймаг, нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 онд хэрэгжүүлэхээр зохион байгуулагдсан нийт 445.2 тэрбум төгрөгийн 6058 төсөл, арга хэмжээний худалдан авах | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллаж байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааны явцын мэдээг 2017 оны 04 дүгээр улирлын байдлаар нэгтгэв. Зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны дүнд гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй гэрээ байгуулж, 100.6 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан байна. Нийт төсөл, арга хэмжээний 40 гаруй хувь нь төсвийн урсгал зардлын санхүүжилтээр гүйцэтгэгдсэн дүнтэй байна.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2012 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүр нэгтгэн тайлагнах зохицуулалт байхгүй тул хэрэгжих боломжгүй. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Сангийн яам худалдан авах ажиллагааны хагас, бүтэн жилийн тайланг хүлээн авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зохицуулалт үйлчилж байгаа болно. | | |
| 68 | 94 | **Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцын тухай**<br><br>2017-10-03, № 43<br><br>Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга нарт даалгав:<br><br>1.1. биелэлт хангалтгүй байгаа 70 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж 2017 оны жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх; 1.2. зорилт, арга хэмжээний биелэлтийг зарцуулсан хөрөнгийн хэмжээ, шалгуур үзүүлэлтийг тухайн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнтэй хамт тайлагнах | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс**<br><br>Монгол Улсын Их Хурлын 2016 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийн 2017 оны жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ) хийж, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А-1/259 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 2017 оны эхний хагас жилийн дүнд дүгнэлт хийж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажилласан. Даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр холбогдох хэлтсийн удирдлагад үүрэг чиглэл өгч хэрэгжүүлэх арга хэмжээ авсан.<br><br>Үндсэн чиглэлд тус байгууллагын эрхлэх асуудалтай холбоотой “Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого”-ын хүрээнд хамаарах 2 зорилт, арга хэмжээ тусгагдсан. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланд урьдчилан тодорхойлж батлагдсан шалгуур үзүүлэлт, түүний зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлгээ хийсэн болно.<br><br><u>Үнэлгээний дүн:</u><br><br>Үндсэн чиглэлд тусгагдсан зорилтын тоо – 2; Үүнээс: | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br><br>Тухайн заалтаар өгсөн үүрэг чиглэл бүрэн биелсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | "Үр дүнтэй" буюу 100 %-ийн үнэлгээтэй – 1 зорилт, арга хэмжээ;<br>"Тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70 % -ийн үнэлгээтэй – 1 зорилт, арга хэмжээ;<br>Үндсэн чиглэлийн биелэлтийн үнэлгээ – "Тодорхой үр дүнд хүрсэн" буюу дунджаар 85.0 %-ийн гүйцэтгэлтэй байна. | | |
| | | **Тэмдэглэл: 23 шийдвэрийн 31 заалт** | | | |
| **Найм. Ерөнхий сайдын захирамж** | | | | | |
| 69 | 95 | **Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай**<br>2016-11-07, № 91<br>2. Уг ажлын явц, үр дүнг Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсгийн дарга (Ц.Ням-Осор)-д үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Монгол Улсад байгаа ОХУ-ын үл хөдлөх эд хөрөнгийн маргаантай асуудлыг зохицуулах үүрэг бүхий шинэчлэн байгуулагдсан Ажлын хэсэг тайлант хугацаанд ОХУ-ын талтай 2 удаагийн өргөтгөсөн хурал, шинжээчдийн түвшинд мөн 2 удаагийн уулзалтыг тус тус зохион байгуулсан. ОХУ-ын өмчийн 17 барилга байгууламжийн хаяг олгогдоогүй байсныг олгох, 15 байршилд кадастрын зураггүй байсныг хийлгэх ажлыг нийслэлийн холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэсэн.<br>Хоёр орны Засгийн газар хоорондын 1971 оны протокол, 1979 оны хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ноот бичгийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 58 дугаар тэмдэглэлээр ГХЯ болон энэхүү ажлын хэсэгт чиглэл өгсөн. Засгийн газрын хуралдааны дурдсан тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу ноот бичгийн төслийг ОХУ-ын талтай зөвшилцөж, хоёр улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхтэй холбоотой баримт материалыг бүрдүүлэх ажлыг гүйцэтгэв. Энэ хүрээнд ОХУ-ын төлөөлөгчид Монгол улсад ажилласан бөгөөд хоёр талын шинжээчид болон Ажлын хэсгийн хамтарсан хуралдааныг 03 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулав. Хамтарсан хуралдаанаар зөвшилцсөний дагуу ОХУ-ын талд ноот бичгийг ГХЯ-наас хүргүүлсэн, хариу ирэхийг хүлээж байна. ОХУ-аас ноот бичгийн хариу ирэхээр УИХ, Засгийн газарт танилцуулна.<br>Монголын талын Ажлын хэсэг уг маргаантай асуудлаар дотоодын холбогдох байгууллагын төлөөлөлтэй 6 удаагийн уулзалт хийж, хоёр талын хэлэлцээг үр дүнтэй болгох бүх талын арга хэмжээг авч ажиллав. | "Хэрэгжих шатанд" – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 70 | 96 | **Ажлын хэсэг байгуулах тухай (Газрын тос боловсруулах үйлдвэр барих)**<br>2017-03-30, № 60<br>2 Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан компанийг үүсгэн байгуулах үйл ажиллагаа болон түүний бүтэц, зохион байгуулалт, дүрмийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулж зохих журмын дагуу батлуулахыг Ажлын хэсэг (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 108 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулан дүрмийг баталж, гүйцэтгэх захирлыг томилсон ба дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлэн Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн .... дугаар гэрчилгээг авсан болно. ТӨБЗГ-ын хуралдаанаар уг компанийн 2017, 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг баталж, гүйцэтгэх захиралтай контракт байгуулан ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Энэхүү тэмдэглэлийн заалтаар өгсөн үүрэг бүрэн хэрэгжиж дууссан тул цаашид хяналтаас хасах саналтай байна. | |
| 71 | 97 | **Ажлын хэсэг байгуулах тухай (Шинжлэх ухааны байгууллагуудын эзэмшиж байгаа төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад үзлэг шалгалт хийх)**<br>2017-04-13, № 65<br>3. Шинжлэх ухааны байгууллагуудын эзэмшиж байгаа барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хийсэн үзлэг шалгалтын дүнг цаашид төрийн өмчийн барилга, байгууламжийн ашиглалтыг сайжруулах, төсөв хэмнэх талаарх саналын хамт 2017 оны 4 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Шинжлэх ухааны байгууллагуудын эзэмшиж байгаа төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн судалгааг хийж, шаардагдах баримт материал, зохих арга хэмжээ авах санал бэлтгэж, ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Ш.Солонгод танилцуулсан. Палеонтологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй конторын барилгыг Баянзүрх дүүргийн прокурорын газарт балансаас балансад шилжүүлэх ажил маргаантай, Палеонтологийн хүрээлэн шилжин байрлах байрны асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байсан тул байрны судалгаа хийсэн. Маргаантай асуудал шийдвэрлэгдэх арга хэмжээ авч, үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн, хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэж, данс бүртгэлд тусгасан. Палеонтологийн хүрээлэн Хими, химийн технологийн хүрээлэнгийн Сонгинохайрхан дүүрэг дэх төвийн байранд шилжин орж байрны асуудал шийдвэрлэгдсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 %<br>Маргаантай асуудал бүрэн шийдвэрлэгдсэн, холбогдох судалгаа хийж танилцуулагдсан тул хяналтаас хасах саналтай байна. | |
| | | **Захирамж: 3 шийдвэрийн 3 заалт** | | | |
| **Ес. Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 72 | 98 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчмыг баримтлан ажиллахыг эрмэлзэж, энэ талаар соён гэгээрүүлэх, сургалтын ажлыг зохион байгуулан ажилласан. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад: 1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах; | Мөн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар тухай бүр албан хаагчдыг сургалтад хамруулах ажлыг тогтмол зохион байгуулсан. 2017 онд 31 лекц, сургалт, семинар зохион байгуулж, албан хаагчийн мэдлэг, чадавхийг бэхжүүлж байна.<br><br>ТӨБЗГ нь албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулахдаа шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан ажиллаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг чанд сахих, мэргэжил, мэдлэгээ байнга дээшлүүлэх талаар заалт тусган хэрэгжүүлж байна. Тус байгууллага албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ, эдгээр үзүүлэлтийг харгалзан үзсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл гаргаагүй. | | |
| | 99 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2017-10-26, № 01<br><br>1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br><br>Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг албан хаагчдад сурталчлан таниулж, уг хөтөлбөрийн хүрээнд 2018 онд хийгдэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Үндэсний хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхэд зардал шаардах ажлуудыг байгууллагын төсөвт тусгаж, хийх ажлыг тодорхой төлөвлөхөд анхаарав. ТӨБЗГ нь уг хөтөлбөр болон Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим ажил, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн тооцоог хийж, 157.8 сая төгрөгийг 2018 оны төсөвт тусгуулав.<br><br>Тайлант хугацаанд, Авлигатай тэмцэх газраас тогтоогдож, хуульд заасан хариуцлага тооцохоор шийдвэрлэгдсэн авлига, ашиг сонирхлын хэрэг, зөрчил бүртгэгдээгүй болно.<br><br>Авлигатай тэмцэх газраас сонгон шалгаруулсан ТӨБЗГ-т ажиллах олон нийтийн дэд зөвлөлийн 3 гишүүнтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавихад олон нийтийн оролцоог хангах боломжийг бүрдүүлэн хамтран ажиллаж эхлээд байна. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |
| | 100 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2017-10-26, № 01<br><br>1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br><br>Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан 2017 онд ТӨБЗГ-т нийт 24 иргэн хандаж санал, хүсэлт, гомдол, ирүүлснийг хүлээн авч, бүртгэлд хамруулан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллав. Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх хүрээнд удирдлагын заалтын дагуу холбогдох албан хаагчид шилжүүлэн, шийдвэрлэлтэд нь бүртгэлээр хяналт тавин ажиллав. Засгийн газрын "Иргэд, олон | “Хэрэгжих шатанд” – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах; | нийттэй харилцах төв"-өөр дамжуулан ирүүлсэн санал, хүсэлт гомдлыг хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай үзүүлсэн эсэхийг албан хаагчдын Үр дүнгийн гэрээний жилийн эцсийн биелэлтийг үнэлж, дүгнэхэд харгалзан үзлэв.<br><br>ТӨБЗГ-т иргэдээс 2017 онд ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтэд тавих хяналтыг эрчимжүүлж, 2017 оны 3 дугаар улирлын тайлан мэдээг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хуралдсан Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Цаашид иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж байх арга хэмжээ авсан. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдээс тус байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг улирал бүр тогтмол мэдээлж байна. | | |
| | 101 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2017-10-26, № 01<br><br>1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br><br>ТӨБЗГ-ын албан хаагчдын цаг ашиглалт, бүртгэлийн байдалд дотоод сүлжээний www.able.mn цахим систем, хурууны хээ унших төхөөрөмжийг ашиглан хэлтэс, албаны удирдлагууд тухай бүр хяналт тавин ажиллаж байна. Цаг бүртгэлийн мэдээг 7 хоног бүр газрын удирдлагад танилцуулан, хоцорсон болон тасалсан албан хаагчид сануулсан ба одоогоор сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр гараагүй байна.<br><br>ТӨБЗГ нь албан хаагчийн мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх замаар тэдний гүйцэтгэл, үр дүнг сайжруулж, ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна. Энэ хүрээнд газрын даргын 2017 оны А/107 дугаар тушаалаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж эхэлсэн. Албан хаагчийн гүйцэтгэлийн үр дүнг байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй холбож, гүйцэтгэл, тайлагналтыг сайжруулахад чиглэсэн сургалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газартай хамтран 2017 оны 12 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав.<br><br>Алба хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулж, үүрэгт ажлыг чанартай гүйцэтгүүлэх, мэдлэг, дадлага эзэмшүүлэх зорилгоор шинээр томилогдсон болон залуу албан хаагчдад газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зарим албан хаагчдын гүйцэтгэх | “Хэрэгжих шатанд” – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | даалгавар", хуваарийг батлан хэрэгжүүлж байна. Нэр бүхий 26 албан хаагч тодорхой хугацаанд уг даалгаврыг биелүүлж, үр дүнг тооцуулахаар ажиллаж байна. | | |
| | 102 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх. | **ТӨБЗГ – ЗХЗХ, Бүх хэлтэст хамаарна.**<br>Албан хаагчидтай байгуулсан үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэж, хариуцсан ажлын байрны чиг үүрэг, албан ажлаа үр дүнтэй биелүүлсэн албан хаагчид ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/192 дугаар тушаалаар үр дүнгийн гэрээний урамшуулал олгов. Үр дүнгийн гэрээний биелэлтээр "С" буюу "Хангалттай", "D" буюу "Дутагдалтай" дүгнэгдсэн 3 албан хаагчид ажлын үр дүнг сайжруулах тухай үүрэг чиглэл өгч, ажил үүргээ гүйцэтгэхэд нь мэргэшил, арга зүйн дэмжлэг, зөвлөгөө өгч, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн 2018 оны зорилтот сургалтад хамруулахаар шийдвэрлэсэн. | "Хэрэгжих шатанд" – 70 % | |
| | 103 | 2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br>Эрхэлсэн үйл ажиллагааны хүрээнд доголдол гаргасан төрийн өмчит 5 хуулийн этгээдийн удирдлага, холбогдох албан хаагчдад хариуцлага тооцож, цаашид зөрчил, дутагдал гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах удирдамж, чиглэлийг холбогдох Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосон. | "Хэрэгжих шатанд" – 70 % | |
| | 104 | 3. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэст хамаарна.**<br>2017 онд ТӨБЗГ-т төсвийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэж, энэ талаар зардал гараагүй.<br>ТӨБЗГ-аас 2016 оны 12 дугаар сард төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг авч, зарцуулагдаагүй цалин, хөлс, урамшуулал, томилолт, тавилга, эд, хогшил, эхлээгүй ажил үйлчилгээний зардлуудыг хэмнэх, төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх асуудлыг тусгасан "Албан даалгавар"-ыг гарган хэрэгжүүлж байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 45 компанийн 32 ТУЗ, түүний дэд хороод, дотоод аудитын тайлан, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын 2016 оны тайланг 2017 оны 01-02 дугаар сард хэлэлцэн дүгнэж, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэв. Захирлын гэрээг цуцалсан тохиолдол гараагүй байна.<br>ТӨБЗГ-ын 2017 оны 90 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн | "Хэрэгжих шатанд" – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам", Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлагыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгаврыг мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.<br><br>Төрийн өмчит хуулийн эдгээдийн санхүүгийн тайлан тэнцлийн 2016 оны баталгаажсан дүнгээр хөрөнгө оруулалтын зардлаас 32.7 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна. 2017 оны тайлан аудитаар баталгаажаагүй байгаа бөгөөд тайлан баталгаажсаны дараа гүйцэтгэх удирдлагын контрактыг дүгнэнэ.<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ажлын цар хүрээ нэмэгдсэн, ажил үйлчилгээний нэр төрөл олширсон нөхцөл байдалтай холбоотойгоор тэдгээрийн ажиллах хүчний тоог бууруулж, зардал хэмнэх боломжгүй байна. | | |
| | | **ЗГ-ын албан даалгавар:<br>1 шийдвэрийн 7 заалт.** | | | |

**(Нийт 9 төрлийн 72 шийдвэрийн 104 заалтын хэрэгжилтийг тайлагнав)**

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)
(2017 оны жилийн эцсийн дүн)

| Д/д | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл | Шийд-вэрийн тоо | Хэрэг-жилтийг тооцсон заалтын тоо | Үүнээс: | | | | | Хэрэгжилтийн явц (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бүрэн хэрэгжсэн (100 %) | Хэрэгжих шатанд (70 %) | Хэрэгжилт хангалтгүй (30 %) | Хэрэгжээгүй (0 %) | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ.) | |
| 1 | Монгол Улсын хууль | 1 | **1** | 1 | | | | | **100.0** |
| 2 | УИХ-ын тогтоол | 3 | **9** | 9 | | | | | **100.0** |
| 3 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 1 | **1** | 1 | | | | | **100.0** |
| 4 | Ерөнхийлөгчийн зарлиг | 2 | **2** | 2 | | | | | **100.0** |
| 5 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж | 1 | **1** | 1 | | | | | **100.0** |
| 6 | Засгийн газрын тогтоол | 37 | **49** | 30 | 9 | 1 | 2 | 7 | **87.1** |
| 7 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 23 | **31** | 21 | 7 | 1 | | 2 | **90.3** |
| 8 | Ерөнхий сайдын захирамж | 3 | **3** | 2 | 1 | | | | **90.0** |
| 9 | Засгийн газрын албан даалгавар | 1 | **7** | | 7 | | | | **70.0** |
| **Хэрэгжилтийн дүн (шийдвэр, заалтын тоо)** | | **72** | **104** | **67** | 24 | **2** | **2** | **9** | **86.1 (дундаж хувь)** |

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ХЯНАСАН:
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДЭД ДАРГА А.ДАГВАДОРЖ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭХИШИГ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ